



ОРОН НУТГИЙН МЭДЭЭЛЭЛ

2020.04.23

Даланзадгад

Өмнөговь аймгийн 2020 оны 04 дүгээр сарын мэдээ

Нэг. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаархи мэдээлэл

Гадаад харилцааны чиглэлээр:

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Баяннуур хотоос Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, халдваргүйжүүлэлт, хамгаалалтыг сайжруулах, хамтын ажиллагааг өргөжүүлж тус хотын зүгээс аймгийн онцгой комисс, шуурхай штабт 30,000 амны хаалт/маск/-ны хандив үзүүлэх ажлыг зохион байгуулж, мэргэжлийн байгууллагуудад хүргүүлсэн байна. Гадаад харилцааны чиглэлээр хийгдсэн ажил арга хэмжээний талаархи 1 дүгээр улирлын хэрэгжилтийг гаргасан.

Нутгийн захиргааны байгууллага, өргөдөл гомдлын чиглэлээр:

Иргэдээс нутгийн захиргааны байгууллага албан тушаалтанд 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар хандан ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ЗГХЭГ-т хүргүүллээ. Тоон гарын үсгийг аймгуудад нэвтрүүлэх ажил хийгдэж байгаатай холбогдуулан 15 сумын тоон гарын үсэг хариуцах албан тушаалтны мэдээллийг нэгтгэн Үндэсний дата төв рүү илгээлээ. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд чанарын олон улсын ISO9001:2015 стандартыг нэвтрүүлж байгаатай холбогдуулан дотоод аудиторын сургалтад хамрагдлаа. Байгууллагын дарга нарын 2020 оны 3 дугаар шуурхай хурлыг 4 сарын 13-ны өдөр зохион байгууллаа. Цахим хэлбэрийн үйлчилгээг бодитой болгох, үр ашгийг нэмэгдүүлэх үүднээс “Гэрэгэ” системс ХХК-тай холбогдон Гэрэгэ киоскыг нэвтрүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

Хүний нөөц, шагналын чиглэлээр:

Төрийн шагналд тодорхойлогдсон 22 иргэний материалыг хянаж аймгийн ИТХ-д уламжлах албан бичгийг гаргуулж хүргүүлсэн.

Дараахь судалгааг хийж Төрийн албаны зөвлөл болон удирдагын академид хүргүүлсэн. Үүнд:

- Мэргэшүүлэх болон чиглүүлэх багц сургалтад хамрагдах албан хаагчдын судалгааг гарган хүргүүлж Ахлах болон дэс түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтууд онлайн аар эхэлсэн.

- Сум байгууллагуудаас Зэрэг дэв ахиулах болон шинээр авах албан хаагчдын материалыг хүлээн авч нэгтгэн Төрийн албаны салбар зөвлөлийн хуралд хэлэлцүүлж Ахлах түшмэлийн ангилалын 3, дэс түшмэлийн ангилалын 31, туслах түшмэлийн ангилалын 11 бүгд 45 албан хаагч, эдгээрээс 20 албан хаагчид зэрэг дэв

шинээр олгож, 25 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулан олгох саналыг аймгийн Засаг даргад уламжилахаар шийдвэрлэн саналыг аймгийн Засаг даргад уламжилсан. Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр 2 албан хаагчаас ирүүлсэн гомдлыг хянаж холбогдох байгууллагын Ёс зүйн зөвлөлд шилжүүлэн, 1 иргэний гомдлыг Маргаан хянан шалгах комисс шалгаж тухайн байгууллагад нь хугацаатай үүрэг даалгавар хүргүүлсэн.

Сум, орон нутгийн чиглэлээр:

Шинэ короновирус өвчин гарсантай холбогдуулан аймгийн шуурхай штабт 3 сарын 9-ний өдөр ажиллав.

Засаг даргын уулзалт:

Аймгийн Засаг даргын А захирамж 2020.04.01-2020.04.17 өдрийн байдлаар 87, Б захирамж 1 тус тус албажсан. Засаг даргатай уулзах иргэдийн бүртгэлээр 12 иргэн бүртгүүлж уулзсан.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төв:

Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд 03-р сарын 20-ны өдрөөс 04-р сарын 19-ны өдрийг хүртэл нийт 19 байгууллага үйл ажиллагаа явуулж 206 төрлийн үйлчилгээг 9404 иргэнд үйлчилгээ үзүүллээ.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн албан хаагчдын үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар 3 бүлэг 15 асуулга бүхий судалгааны маягт гарган нийт 40 иргэнээс судалгаа авч ажиллаж байна. ТҮНТөвийн харьяа байгууллагуудад холбогдолтой 2 санал, гомдол ирсэн байна. Мөн үйлчилгээний чанар хүртээмжийн талаар 2 судалгааны маягт гарган G-mail аппликейшн нэвтрүүлэн ажиллаж эхний 13 судалгааны дүнг гаргаж дүгнэлт хийж ажиллаж байна. Дүгнэлтээс харахад Нотариат, Өмнөд бүсийн цахилгаан түгээх станц, Дулааны цахилгаан станцын төлөөлөл байх шаардлагатай гэсэн судалгаа гарсан болно. Үйлчилгээ үзүүлсэн иргэдийн тоог өдөр бүр авч 7 хоногийн мэдээг нэгтгэн мэдээллийн самбарт байршуулан ажиллаж байна. Төрийн үйлчилгээний албаны албан хаагчдын санал санаачлагаар “Бүтээлчээр сэтгэе” уралдаан зарлаж ТҮНТөвийн байрны дотор болон гадаад үзэмжийг сайжруулах 22 төрлийн ажлыг хийж өнгө үзэмжийг сайжруулан ажиллалаа.

Хууль, эрх зүйн чиглэлээр:

- “Бумбат даваа” ХХК-ийн нэхэмжлэлтэй, аймгийн Засаг даргын Тамгын газарт холбогдох иргэний хэргийг эцэслэн шийдвэрлүүлсэн.
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон захиргааны байгууллагаас санал авч хүргүүлсэн.
- Худалдан авах ажиллагаатай холбоотой хоёр хуулийн этгээдийн гомдлыг шийдвэрлэсэн
- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний нэгдүгээр улирлын хэрэгжилтийг гарган хүргүүлж, хоёрдугаар улирлын төлөвлөгөө батлуулсан.
- Сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарын 2020 оны 1-р улиралд гаргасан захирамж, тушаалыг хянаж зөвлөмжийг хүргүүлсэн
- Улсын Их Хурлын болон Орон нутгийн сонгуулийн хорооны сургалтад албан хаагчид хамрагдаж гэрчилгээ авсан.
- Цагдаагийн газартай хамтран “Бид нэг амьтай” аяны хүрээнд зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх сургалт, яриаг аймгийн Нийгмийн даатгалын

хэлтэс, Захирагчийн ажлын алба, Зэвсэгт хүчний 0167 дугаар анги, Хилийн 0131 дүгээр анги, Эрүүл мэндийн газрын хамт олон зэрэг нийт 330 гаруй төрийн албан хаагчдад хийсэн.

- Авлигатай тэмцэх газартай хамтран Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүдэд цахим сургалтыг зохион байгуулсан
- 04 сарын 28-29-ний өдрүүдэд Хүний эрхийн комисстой хамтран жендерийн сургагч багшийг чадавхижуулах цахим сургалтыг зохион байгуулахаар ажиллаж байна
- Хууль, эрх зүйн хэлтсийн хяналтад байдаг зарим үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд “Говь” HD телевизтэй видео контент хийх, захиалгат нэвтрүүлэг хийг 2.4 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан
- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийж гүйцэтгэж буй Улсын бүртгэлийн хэлтсийн дээврийн засварын ажил, Шүүхийн шинжилгээний албаны гадна тохижилтын ажил, Ханбогд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын гүйцэтгэлийг хүлээн авсан байна.
- Архивын ерөнхий газар даргын тушаалаар “Баримтын бүрэлдэхүүн , тоо хэмжээ, хадгалалтын талаарх ” тоо мэдээг тус архивын тасагт хөмрөг үүсгэгч нийт 101 байгууллагуудын баримтын мэдээг шивж явуулсан болно. Мөн сонгуулийн жилтэй холбогдуулан сан хөмрөгт хадгалагдаж байгаа 2000-2017 онуудын Сонгуулийн баримтад Эрдэм шинжилгээ техник боловсруулалтын ажлыг гүйцэтгэж байна.
- Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу лавлагааны ачаалал ихсэж 4 сард нийт 271 иргэнд үйлчилсэн байна. Мөн энэ ажлын хүрээнд бүх сумдын Засаг даргын тамгын газарт хадгалагдаж байгаа 2017-2019 онуудын “А” дансыг татан авах ажлын зохион байгуулж байна.

Зам тээвэр, барилга, нийтийн аж ахуйн чиглэлээр:

- Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэний нөхөн олговрыг Даланзадгад зорчигч тээвэр ОНӨААТҮГ-д 1, 2, 4 сарын захирамжийг гарган СТСХ-т хүргүүлсэн. Авто тээврийн төв, Цогтцэций салбарын 2020 оны авто тээврийн хэрэгслийн улсын үзлэг явуулах хуваарийг гарган аймгийн Засаг даргын 2020 оны А/222 тоот захирамжийг хүргүүлэн, улсын үзлэгийг эхлүүлсэн байна.
- Хүрмэн сумын орлогод нийцсэн орон сууцны барилга-Эм Би Эф ХХК, Нутгийн удирдлагын ордны авто зогсоолын ажил- Таны зам ХХК, 5-р сургууль, 25-р цэцэрлэгийн авто зогсоол, тохижилтын ажил-Эмүцогт ХХК, 0131-р ангиас Гурван сайхан хороолол чиглэлийн дугуйн зам-Таны зам ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээг тус тус байгуулж, ажлыг эхлүүлсэн. Мөн дээрх ажлуудын зохиогчийн хяналтын гэрээг байгуулан ажиллалаа.
- Баяндалай-Гурвантэс чиглэлийн 10 км хатуу хучилттай авто зам, 4-р орон сууцны дахин төлөвлөлт, Нанзад хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах, Номгон сумын төвийн хатуу хучилттай авто зам барих ажлуудын тендер сонгон шалгаруулалтад шаардлагатай баримт материалыг бэлтгэн ХААГ-т хүргүүлж, сонгон шалгаруулалтыг зарласан.
- Дахин төлөвлөлтийн 3 орон сууц, Музей, Театрын барилгуудад явцын хяналтыг тогтмол хийж ГХБХБГ-ын захиалагчийн хяналтын талаарх

мэдээллийг тогтмол авах, баталгаажсан гүйцэтгэлийн санхүүжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Мэдээ, тайлан, хэрэгжилт:

1. Үндэсний хөтөлбөрийн төлөвлөгөөг батлуулах
2. Төрийн албан хаагчийн 2020 оны 2-р улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан, 1-р улирлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргасан.

Албан бичиг төлөвлөлт

1. Гүйцэтгэлийн баталгаа чөлөөлөх, санхүүжилт хүссэн, болон зохион байгуулалтын шинжтэй, тодорхойлолт хүргүүлэх гэх мэт 9 хариутай албан бичгийг шийдвэрлэн, аймгийн Засаг даргын 12 захирамжийг төлөвлөж, холбогдох зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилласан

Газрын харилцаа, хот байгуулалтын чиглэлээр

- Аймгийн Засаг даргын захирамжаар 8 иргэний газрын өмчлөлтэй холбоотой шийдвэр гаргасан.
- Даланзадгад сумын "Дөрөв дүгээр сургууль чиглэлийн чулуун замын зураг төсөл, төсөв боловсруулах" ажлын гэгээг "Геозураглал" ХХК-тай байгуулж ажлыг эхлүүлсэн.
- Даланзадгад сумын "Гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээний өргөтгөлийн зураг төсөл, төсөв боловсруулах" ажлын гэгээг "Монкузбасс" ХХК-тай байгуулж ажлыг эхлүүлсэн.
- Цогтцэций сумын Шинэ суурьшлын бүсийн цахилгааны шугам сүлжээний зураг төсөл, төсөв боловсруулах ажлын гэгээг "Итгэлийн хад" ХХК-тай байгуулж ажлыг эхлүүлсэн.
- Цогт-овоо сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн зураг төслийг боловсруулах ажлын гэрээг "Тоонто гранд" ХХК-тай байгуулж ажлыг эхлүүлсэн.
- Даланзадгад сумын 5-р багийн төвийн барилгын зураг төслийн ажлыг дуусгаж барилга угсралтын ажлын сонгон шалгаруулалтыг зарлав.
- Буянт хотхоны зоогийн газрын зураг төслийг боловсруулж барилга угсралтын ажлын сонгон шалгаруулалтыг зарлав.

Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн чиглэлээр

- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ийг шинэчлэн баталсны дагуу Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгох хөнгөлөлттэй зээлд хамрагдах төсөл хүлээн авах ажиллагааг 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс 30 хоногийн хугацаатай нийтэд нээлттэйгээр зарлаад байна.
- Инжерийн хийцтэй худаг гаргах ажлыг "Хишиг юниверс" ХХК, "Голден хилл" ХХК-уудтай гэрээ байгуулан ажлыг эхлүүлээд байна.
- Хариуцсан салбарт нийт 12 үндэсний хөтөлбөр хэрэгждэг ба хөтөлбөрүүдийн 2020 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
- Аймгийн ХХААГ-ын мал хэмжих зориулалтын багаж, тоног төхөөрөмжийн гүйцэтгэгчээс хүлээн авч ашиглагч байгууллагад хүлээлгэн өгсөн.

- Даланзадгад сумын хүн амын хавар, зуны улирлын махны хэрэгцээг хангах зорилгоор “Нөөцийн мах хөнгөлөлттэй үнээр худалдан борлуулах” ажлыг “Хан сайхан говь” ХХК, “Өнөд өвлөх урлахуй” ХХК-уудтай гэрээ байгуулан гүйцэтгүүлэн ажиллаж байна.

Эдийн засаг, хөрөнгө оруулалт, төлөвлөлт, худалдаа үйлчилгээний чиглэлээр

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 2021 оны төслийн саналыг ирүүлэх чиглэлийг сумдад болон Засаг даргын дэргэдэх байгууллагуудад боловсруулан хүргүүлсэн бөгөөд аймгийн ЗДТГ-ын харьяа хэлтсүүд хариуцсан чиглэлийн дагуу саналыг боловсруулах ажил хийгдэж байна.
- Холбогдох хууль, журамд зааснаар СЯ-аас аймгийн Засаг даргад 2020 оны 9/2029 тоот албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу тус яамнаас эрхлэн хөтөлж буй цахим системд аймгийн ЗДТГ-ын хэлтсүүдээс ирүүлсэн саналыг бүрдүүлсэн баримт бичгийг үндэслэн оруулах ажлыг 4 сарын 30-ны дотор хийж, ТЕЗ-чид хүргүүлж ажиллана.
- Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой 16 аж ахуйн нэгжийн саналыг 2020 оны 04 сарын 01-ний хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, ажиллалаа.

Уул уурхай эрчим хүчний салбарын чиглэлээр

- “Буянт хотхон хүүхдийн зусланг цахилгаан дамжуулах агаарын шугамаар холбох” багц-1, Багц-2, Багц-3 тус тус ажлын гэрээ байгуулсан.
- Сэврэй сумын төвийн дулааны шугам сүлжээний өргөтгөл шинэчлэлтийн ажил, Даланзадгад сумын 7 дугаар багийн төв, Аргалант хорооллын 2 дугаар хэсгийн дулааны шугамын өргөтгөл тус тус ажлын гэрээ байгуулсан.
- Булган сумын төвийн гэр хорооллын 0.4 кВ-ын цахилгааны шугамыг өргөтгөл ажлын гэрээ байгуулсан.
- Манлай сумын төвийн гэр хорооллын 0.4 кВ-ын цахилгааны шугамыг өргөтгөл ажлын гэрээ байгуулсан.
- Манлай сумын төвийн дулааны шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлтийн ажлын гэрээ байгуулсан.
- Даланзадгад сумын төвийн гадна гэрэлтүүлэг, гэрлэн чимэглэлийг нэмэгдүүлэх ажлын зураг төсөв, төсөл боловсруулах гэрээ байгуулсан.
- Даланзадгад сумын 18-р байрны дулаан хангамжийг засварлах, Баян-Овоо сумын төвийн дулаан шугам сүлжээг шинэчлэх, өргөтгөл ажлын тендер зарласан.
- Ханбогд сумын төвийн цэвэр, бохир усны шугам сүлжээний өргөтгөлийн ажлын тендер зарлахад бэлтгэсэн.

Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр

- 2015 оноос хойш жил бүр Өмнөговь аймгийн хүн амын ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулан, батлуулж хэрэгжилтийг хангуулж, дүгнүүлэх ажлыг зохион байгуулан хэрэгжүүлсээр ирсэн.
- Аймгийн хүн амын ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангуулж ажиллах үүрэг чиглэл бүхий ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2020 оны А/49 захирамжаар шинэчлэн байгуулсан. Тус ажлын хэсэг нь

ундны усны аюулгүй байдлын 2020-2022 оны төлөвлөгөө боловсруулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 88 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжилтийг зохион байгуулж ssбайна. Даланзадгад сумын 150 өрхийг ундны усны стандарт саваар хангах, Баяндалай, Гурвантэс, Ноён, Сэврэй сумдын хүн амын ундны усанд ашиглаж буй гүний худагт ус цэнгэгжүүлэх, халдваргүйжүүлэх төхөөрөмж суурилуулах ажлуудын техникийн даалгаврыг боловсруулан 2020.03.25-нд батлуулж худалдан авах ажиллагааны тендерийг 2020.03.31-04.14 хүртэлх хугацаагаар зарлагдаад байна.

- Орон нутгийн байгаль орчны хүний нөөц, идэвхитэн байгаль хамгаалагчийг чадавхижуулж, ажиллах нөхцлийг сайжруулах ажлын тендер 2020.01.28-03.02-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулагдаж гүйцэтгэгчээр Гайхамшигт говь ХХК шалгарч гүйцэтгэсэн. Уг ажлын гүйцэтгэлийг хүлээн авах комисс аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын А/197 дугаар тушаалаар томилогдож 2020.04.02-ны өдөр ажиллаж акт үйлдэн ашиглагч байгууллагад бүрэн хүлээлгэн өгөв. Уг ажлын хүрээнд Проектор-1, проекторын дэлгэц 1, суурин компьютер 5, принтер 4, усны чанар хэмжигч багаж 1, усны түвшин хэмждэг багаж 1, дуран 5, зургийн аппарат 6 ширхэг нийт 8 төрлийн 23 ширхэг тоног төхөөрөмжийг нийлүүлээд байна. Тус ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгө 54,4 сая төгрөгөөр гүйцэтгүүлэв.
- Булган, Мандал-Овоо, Номгон сумдад нийтийн эзэмшлийн ногоон байгууламж байгуулах ажлын эрх шилжүүлж 04 сарын байдлаар Мандал-Овоо сум тендер шалгаруулалт зарлаж гүйцэтгэгчийг шалгаруулж ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулагдсан, бусад сумд нь үнэлгээний хороо байгуулагдан тендер зарлах шатандаа явагдаж байгааг эрчимжүүлж ажиллах чиглэлийг хүргүүлж хяналтыг тавьж ажиллаж байна. Манлай сумын Ногоон байгууламж байгуулах ажлын худалдан авах ажиллагааны тендер 2020.03.27-04.27-ны өдөр хүртэлх хугацаагаар зарлагдсан. Даланзадгад сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт хийгдэх ногоон байгууламжийн услалтын систем суурилуулах ажлын үргэлжлэл гэрээний дагуу 04 сарын 01-ний өдрөөс эхлээд байна. Захирагчийн ажлын алба нь ногоон байгууламжийн арчилгаа хамгаалалтыг гүйцэтгүүлэх гэрээт ажилчдыг авч 40 га ногоон байгууламжийн нөхөн тарилт арчилгаа хамгаалалтын ажлыг 04-11 сар хүртэлх хугацаанд гүйцэтгүүлэхээр ажил эхлүүлээд. Уг ажлын зардалд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зардал 500,0 сая төгрөгийг шийдвэрлээд байна.
- Номгон суманд хөв цөөрөм байгуулах ажлын тендер 2020.02.27-03.30-ны өдөр хүртэлх хугацаанд зарлагдаж гүйцэтгэгчээр "Болор-Ус" ХХК шалгарч гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлж, ажил гүйцэтгүүлж, гэрээ байгуулах хугацаандаа явагдаж байна.
- Даланзадгад сумын агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг аймгийн Засаг даргын А/203 дугаар захирамжаар байгуулсан. Уг ажлын хэсэг нь УБ хот дахь таван толгой түлш ХХК-ийн үйл ажиллагаатай танилцаж туршлага судлах ажлыг 2020.03.12-14-ний өдрүүдэд зохион байгуулсан. аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020.03.20-ны өдрийн 89 дүгээр тогтоолоор Даланзадгад сайн түлш ОНӨААТҮГ-ыг байгуулж дүрмийг баталсан. Уг ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захирлыг томилхоор АТГ-т материал хүргүүлээд байна.
- 2020 онд Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хийгдэх хөрөнгө оруулалтын ажлуудаас худалдан авах ажиллагааны 03-04 сарын төлөвлөгөөнд нийт 13 ажил төлөвлөгдөж батлагдсаны дагуу ажлын даалгавар боловсруулагдаж батлуулан тендер зарлагдсан байна.

Эрүүл мэндийн чиглэлээр:

- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн коронавируст халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангаж нэн шаардлагатай багаж тоног төхөөрөмжийн хангалт, нөөцийг бүрдүүлэх, эмч мэргэжилтнүүдийн дархлааг дэмжих зорилгоор иргэд аж ахуй нэгжүүдээс ирүүлсэн хандив тусламжийн 23 816 000 /Хорин гурван сая найман зуун арван зургаан мянга/ төгрөгний санхүүжилтээс шийдвэрлэн бэлэн байдлыг хангасан. Сум дундын эмнэлгийн коронавируст халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдал хариу арга хэмжээг эрчимжүүлж, шаардлагатай эм, материал болон тэнд ажиллаж буй төрийн албан хаагчийн хувийн хамгаалах хэрэгсэл, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодисын нөөц бүрдүүлэхэд шаардлагатай зардалд 33 694 000 /Гучин гурван сая зургаан зуун ерэн дөрвөн мянга/ төгрөгийг зарцуулж бэлэн байдлыг хангасан.
- Аймгийн хэмжээнд шинэ коронавирусын халдварын болзошгүй сэжигтэй 1 тохиолдлыг 21 хоногын хугацаанд Ханбогд сум дундын эмнэлэгт тусгаарлаж, тандалт, судалгаа шинжилгээнд хамруулан тусгаарлах байрнаас гарган гэрийн ажиглалтад шилжүүлсэн. Гэрийн ажиглалтанд 6 хүнийг хянаж байгаа бөгөөд одоогоор халдварт өвчний шинж тэмдэг зовиур илрээгүй.
- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн мэс заслын тасгийн хагалгааны хэсгийг вакуум болгож засварлах, цээжний рентген зураг авах өрөөний туяаны хамгаалалт хийх ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулан ажил гүйцэтгүүлж эхэлсэн. Мөн Бүсийн оношилгоо эмчилгээний төвд ходоод, бүдүүн, шулуун гэдэс, уушигны дурангийн аппарат, гэмтлийн тасгийн нэн шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх ажилд гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар багийн эмч нарт түргэн тусламжийн мотоциклоор хангах ажлыг зохион байгуулж, 5 сумын 11 багийн эмчид түргэн тусламжийн мотоциклыг хуваарилаад байна.

Боловсрол, Соёл спортын чиглэлээр:

- 2020 оны 04 дүгээр сарын 17 нд Номгон сумын Соёлын төвийн барилга “Соёл спортын цогцолбор” болон өргөжиж нээлт хийн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.
- Даланзадгад сумын 1 дүгээр сургуульд Англи хэлний кабинет байгуулах ажлын гүйцэтгэгчээр “Сүлдэт жороо” ХХК шалгаран, гэрээ байгуулж, ажлыг гүйцэтгэж байна.
- Баяндалай сумын дотуур байрны засварын ажлын гүйцэтгэгчээр “Даян байгаль” ХХК шалгарч, гэрээ байгуулан, засварын ажлыг гүйцэтгэж байна.
- Ханхонгор сумын сургууль, дотуур байрны засварын гүйцэтгэгчээр “Эвт цахирал” ХХК, “Хүслэн хийморь” ХХК тус тус шалгарч, ажил гүйцэтгэх гэрээг байгуулан ажлын гүйцэтгэж байна.
- Ханхонгор сумын сургуульд хөгжмийн зэмсэг нийлүүлэх ажлын гүйцэтгэгчээр “Эгшиглэн магнай” ХХК шалгарч, гэрээ байгуулан ажлыг гүйцэтгэж байна.
- Даланзадгад сумын 1 дүгээр сургуулийн дотуур байрны засварын гүйцэтгэгчээр “Дүжий хайрхан” ХХК шалгарч, гэрээ байгуулж байна.
- Хүрмэн сумын 320 хүүхдийн сургуулийн барилгын гүйцэтгэгчээр “Тэлмүүн доной” ХХК-ийг шалгаруулж, ажил гүйцэтгүүлэх гэрээг байгуулан, барилгын ажлыг эхлүүлж байна.

- Боловсролын салбарыг дэмжих жилийн хүрээнд багш бүрийг хичээлийн хэрэглэлээр хангах ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд аймгийн хэмжээний нийт 942 багшид олгохоор шийдвэрлээд байна. Тус ажлын гүйцэтгэгчээр “Соёмбо говь” ХХК шалгарч, гэрээ байгуулан, ажлыг 100 хувь хийж гүйцэтгэн орон нутагт хүлээлгэж өглөө.
- Энэ хичээлийн жилд аймгийн хэмжээнд 12 дугаар ангийг 603 хүүхэд төгсөх бөгөөд элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх ажлыг цахим хэлбэрээр зохион байгуулж байна. Цахимаар сорил авах ажлыг тогтмол зохион байгуулж байгаа бөгөөд, сорилын дүнд үнэлгээ хийж, үнэлгээний дагуу хоцрогдолтой агуулгаар цахим хичээл зохион байгуулж байна.
- Боловсролын салбарыг дэмжих жилийн хүрээнд сургуулиудын ариун цэврийн ерөөг стандартын дагуу засварлаж тохижуулах ажлыг зохион байгуулж, нийт 13 сургуульд 80.0 сая төгрөгийг олгож, засвар, тохижилтын ажлыг хийж байна.

Санхүү, төрийн сангийн чиглэлээр:

- Улс болон орон нутгийн төсвийн байгууллагуудын Төсвийн гүйцэтгэлийн 3-р сарын мэдээг хүлээн авч орлого, зарлага эдийн засгийн ангилал тус бүрээр Фрибаланс программ дахь төсвийн гүйцэтгэлтэй тулган шалгаж, Сангийн яамны Төрийн сангийн газарт мэдээг татууллаа.
- Нийт 43 төсөвт байгууллагуудын 2020 оны 3 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг хүлээн авч, хянан баталгаажуулсан.
- Төсвийн орлогын 3-р сарын мэдээг Аймгийн Татварын газартай тооцоо нийлж, баталгаажуулсан.
- Орон нутгийн байгууллагуудын 3 сарын байдлаарх өр авлагын мэдээг авч, нэгтгэн Сангийн яаманд илгээлээ.
- Сумдын санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвийн байгууллагуудын 4-р сарын санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олголоо.
- Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын 4-р сарын санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олголоо.
- Аймгийн төрийн сангийн харъяа 43 төсвийн байгууллагын үндсэн данс болон, нэмэлт санхүүжилтийн дансны төлбөр тооцоог өдөр тутамд төрийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу, эдийн засгийн ангилалын дагуу хянаж, хийж гүйцэтгэн, баталгаажуулж ажиллалаа.
- Өмнөговь аймгийн нийт 15 сумаас ирүүлсэн Фрибаланс программд бэлтгэн нийлүүлэгчийн данс нэмэх, бэлтгэн нийлүүлэгчийн мэдээллийг засварлах, Санхүү албаны дарга нарын гүйлгээ баталгаажуулаагүй орхигдуулсан эсэх, төсвийн байгууллагын орлого хаах журналын бичилт хийх, сумдын орлого хаасан эсэхэд хяналт тавин ажиллалаа.
- Төрийн сангийн фрийбаланс программд бүртгэлгүй хувь хүн болон аж ахуй нэгж байгууллагуудын Санхүү, төрийн сангийн хэлтэст ирүүлсэн хүсэлтийн дагуу регистрийн дугаар, нэр, арилжааны банкны дансны дугаарыг төрийн сангийн фрийбаланс программд шинээр бүртгэсэн.
- 2019 оны жилийн эцсийн тайланг аймаг, сумын орон нутгийн төсвийн байгууллагуудаас хүлээн авч нэгтгэж дуусан аймгийн Төрийн аудитын газарт тайлангаа шалгуулж, аудитын дүгнэлтээ авсан.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ-дотоод аудитын чиглэлээр:

№	ТӨЛӨВЛӨСӨН АЖИЛ	ХЭРЭГЖИЛТ	ХУВЬ
---	-----------------	-----------	------

1	Арга хэмжээ: УИХ, Засгийн газар болон холбогдох бусад байгууллагаас батлан гаргасан тогтоол шийдвэрийг хяналтад авч, удирдлагуудад танилцуулан, хэрэгжүүлэх байгууллага албан тушаалтанд хүргүүлэх	Засгийн газрын тогтоол 2, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 4 ирснийг удирдлагуудад танилцуулан холбогдох албан тушаалтанд хүргүүлэв.	100
3	Арга хэмжээ: Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдийн тогтоолоор аймгийн Засаг даргад үүрэг болгосон заалт арга хэмжээ, төлөвлөгөө, ажлын хэсэгт даалгасан үйл ажиллагааг хяналтад авч, мэдээллийг удирдлагуудад танилцуулан, хэрэгжилтийн явцад хяналт тавих	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдийн нийт 51 тогтоолыг бүртгэн авч хяналтад авах шаардлагатай тогтоолыг холбогдох албан тушаалтанд хүргүүлэв.	100
4	Арга хэмжээ: Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврыг хяналтад авч эзэнжүүлэх	Аймгийн засаг даргаас гарсан 64 захирамжийг хяналтад авч холбогдох албан тушаалтанд хяналтад өгч ажиллав.	100
5	Арга хэмжээ: Сумдын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх	Сумын Засаг даргын Тамгын газрын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх удирдамжийг гарган сумдад хүргүүлэв.	50
	Арга хэмжээ: Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд хяналт хийх	Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд хийх хяналтыг эхлүүлж мэдээ мэдээллийг нэгтгэв. Тайлангийн явц 50 хувьтай байна.	50
7	Арга хэмжээ: Хэлтсийн дотоод ажлын талаар	Хэлтсийн 2020 оны гүйцэтгэл сайжруулах хагас жилийн төлөвлөгөөний 1-р улирлын хэрэгжилтийг гаргасан. Мөн мэргэжилтнүүд 1-р улирлын төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргаж 2-р улирлын төлөвлөгөөг боловсруулж ТЗУХ-т хүргүүлэв.	100
		Сум, агентлаг, төсвийн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж ажилтнуудын 2020 оны сургалтын төлөвлөгөөг батлуулан сум агентлагт хүргүүлэв.	100

Олон нийттэй харилцах чиглэлээр:

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ, НЭВТРҮҮЛЭГ

- Өмнөговь аймгийн албан ёсны сайт, фэйсбүүк, гэрээт сайтуудад аймгийн хэмжээнд болж өрнөж буй үйл явдлын 74 мэдээ мэдээллийг нийтэлсэн байна. Өлзий тв, Малчин тв болон гэрээт тв-д цаг үеийн 8 сурвалжлага мэдээг бэлтгэж өглөө. Өлзий тв-д 7 хоногийн тойм 4 дугаарыг бэлтгэж гаргасан байна

ИРГЭДЭЭ СОНСОХ 70530001 УТСАНД ИРСЭН САНАЛ ХҮСЭЛТ

- Иргэдээ сонсох утсанд 4-р сарын байдлаар 5 санал хүсэлт гомдол ирснээс 3 хүсэлт 1 хүсэлт 1 санал ирсэн байна. Иргэдээс ирсэн санал хүсэлтийг холбогдох албан тушаалтанд уламжилж цаг алдалгүй шийдвэрлэж байна. Өдөрт дунджаар 20-25 дуудлага ирж төрийн албан хаагчийн утас болон өндөржүүлсэн бэлэн байдлын талаарх мэдээ мэдээлэл болон аймгийн онцгой комиссоос гаргасан шуурхай мэдээлэл авахаар залгаж байна.

ХУРЛЫН ТАНХИМУУД:

- Шинэ төрлийн Коронавирусээс урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутагт бэлэн байдлын хэсэгчилсэн зэрэгт шилжсэнтэй холбогдуулан олон нийтийн ажил, арга хэмжээ, сургалт, зөвлөгөөн, уулзалтыг зохион байгуулахыг хориглосон хэвээр байна. Аймгийн Онцгой комиссын “Шуурхай штаб” 2 давхарын “Говь” танхимд байрлан тогтмол ажиллаж байгаад бөгөөд иргэдэд 7053-3336, 7053-3337 дугаар утас үйлчилж байна.

ОНЦЛОХ АЖЛУУД

- Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимтэй зохион байгуулсаар байна.
- Онлайн хурлыг 15 сумын хэмжээнд зохион байгуулав.

СУМ, ОРОН НУТГИЙН 4 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭЛЭЛ

БАЯНДАЛАЙ СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гаргасан бодлого шийдвэр

Сумын Засаг даргаас 4 захирамж гарсан байна.

Хоёр.Хурал зөвөлгөөн, сургалт, семинар, уулзалт

Цахимаар эрүүл мэндийн зөвлөгөө, маск зүүх ач тусын талаар мэдээлэл хийсэн.Мөн өрх гэр бүлийг дэмжих жилийн нээлтийг цахимаар хийсэн.

Аймгийн Тамгын газраас зохион байгуулсан цахим хуралд төрийн бүх албан хаагчид болон албан байгууллагуудын дарга эрхлэгч нар сууж мэдээ мэдээллийг сонссон.

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн Хурлыг 1 удаа Тэргүүлэгчдийн 57,1 хувийн ирцтэй, халдвар хамгааллын дэглэмийг баримтлан Иргэний танхимд хуралдаж 5 асуудлыг хэлэлцэн 5 тогтоол гарч эзэнжүүлсэн байна. Хуралдаанаар суманд тулгамдсан асуудал болох хог хаягдлын талаар судалгаа дүгнэлт хийж, Тэргүүлэгчдийн 2017 оны 38 дугаар тогтоолын хэрэгжилтийг хэлэлцүүлэв. Үүнд: “Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, устгах, үйл ажиллагааг санхүүжүүлэх, зарцуулах” журмын хэрэгжилтийг тооцов.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээ

Хөдөө аж ахуй: Баяндалай сумын газар тариалан эрхлэгчдийн мэдээлэл 2020 онд тариалах газар тариалан, хүлэмж, жимс жимсгэнэ, зоорь, төмс, хүнсний ногооны судалгааг сумын түвшингээр, бог малын ээмэгжүүлэлтийн судалгаа, 7 хоног бүрийн 3 дахь өдөр нөөцийн мэдээ, түүхий эд бэлтгэлийн мэдээ, багуудын хэмжээнд ноолуур урьдчилан бэлтгэх судалгааг гаргаж ХХАА-н газарт хүргүүлсэн.

Нийгмийн даатгал: Сайн дурын гэрээг нийт 13 иргэнтэй байгуулж, өндөр насны шинэ тэтгэврийн хувийн хэрэг 4 иргэнд нээсэн. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг 22 иргэн төлсөн байна.

Хөдөлмөр халамжийн үйлчилгээ: 04 сарын 01 нд тэтгэвэр, тэтгэмжийн олголтын жагсаалтыг гаргаж явуулсан. Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурал хуралдаж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зарлагдсан төсөлд ирүүлсэн төслүүд болон шинээр асаргаанд орох иргэний материалыг хэлэлцэж шийдвэрлэсэн.

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас ахмадуудад хүндэтгэл үзүүлж витамин, санитол, маск тараасан бөгөөд нийт 30 ахмадад олгож тайлан гаргаж явуулав.

Хөдөлмөрийн аюулгүй байдлын нэг сарын аян зохион байгуулагдаж байгаа бөгөөд ЕБСсургууль, Гурванмөнх, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв зэрэг албан байгууллагуудад хөдөлмөрийн аюулгүй байдлын болон ажлын байранд тавигдах эрүүл аюулгүй орчин бүрдүүлж ажиллах заавар, зөвлөмжийг албан бичгээр хүргүүлж ажиллав.

Цахимаар сайхан бичгийн уралдаан, гар зургийн уралдааныг зохион байгуулан дүнг гарган олон нийтэд танилцуулсан.

Зорилтод өрхийн айлуудад маск болон гар ариутгалын бодис тараасан. Мөн албан байгууллагууд ээлж ээлжээр эргүүл хийж ажиллаж байна.

Сумын төвийн бүх айл өрхийн жорлон, муу ус цооногт авгалдайн устгал, мөн бүх гудам талбай, нийтийн эдэлбэр газар, аж ахуй нэгж, албан байгууллагуудад ариутгал хийсэн.

Соёлын төв, дотуур байрны засварын ажил, өвс тэжээлийн агуулах барих зэрэг хөрөнгө оруулалтын ажлууд хийгдэж байна.

БАЯН-ОВОО СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн:

ЗДТГазар: Сумын Засаг даргаас А захирамж 7 гарсныг хэрэгжүүлэн ажиллав.

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт:

ЗДТГазар: Монгол Улсын Ерөнхийлөгчийн Таван толгой нүүрсний уурхайгаас Гашуун сухайт хилийн боомт хүртэлх төмөр замын ажлын явцтай танилцах уулзалт хуралд оролцлоо.

Монгол улсын шилдэг сум шалгаруулах төвийн бүсийн аймгуудын уулзалт зөвлөгөөнд сумын засаг дарга оролцлов.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаагаа цахимаар хэрэгжүүлэх аймгийн нэгдсэн 3 удаагийн цахим хуралд хамрагдлаа.

Өмнөговь аймгаас байгууллагын дарга эрхлэгч, алба хаагчдад хийсэн цахим хурлын бэлтгэл ажлыг хангаж ажиллаа. Хамтарсан багийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулах хүсэлтийг ИТХ-ын Тэргүүлэгчдын хуралд танилцууллаа. Амны хаалт зүүх санамж материалыг албан хаагчдын өрөөний хаалганд байршуулж ажиллалаа.

ГБХЗХГазар, УБ-с Хүүхдийн эрх хамгааллын" Үжин " төвийн тэргүүн Д.Ундраа ирж сургалт кохон байгуулав.

ХАБЭА-н сарын аяныг цахим хэлбэрээр амжилттай эхлүүлэн, цахимаар тогтмол гарын авлага мэдээллийг хуваалцаж байна.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил, арга хэмжээ:

ЗДТГазар: Сумын 2020 оны үндсэн чиглэл, аймгийн хөрөнгө оруулалтын хүрээнд төсвийн болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 4 хөрөнгө оруулалтын ажлуудын цахим сонгон шалгаруулалтыг зарлаж сонгон шалгаруулах ажлуудыг зохион байгууллаа.

Багийн засаг дарга нар Орон нутгийн сангийн журмын дагуу малчин айл өрхүүд багийн иргэдийнхээ санал асуулгыг авлаа.

Гашуун сухайт авто зам ХХК-ны удирдлагуудтай 2020 онд сум орон нутагт хийх хөрөнгө оруулалтын ажлын талаар уулзалт зөвлөгөөнийг сумандаа хийлээ.

Сумынхаа худалдаа үйлчилгээний цэгүүд, үйлчилгээний байгууллагуудад халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын зөвлөмж журмыг хэрхэн мөрдөж ажиллаж байгаа талаар тогтмол яханлт үнэлгээ хийж ажиллалаа.

Сумын олон нийтийн гудамж талбай, хүүхдийн тоглоомын талбайнуудад эрүүл мэндийн төвтэй хамтран ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг 7 хоног бүр хийж байна.

Хүүхэд хамгааллын чиглэлээр сэрэмжлүүлэг зөвлөмж бэлтгэн олон нийтэд сурталчилах ажлыг сумын цахим хаягт байршууллаа.

Орон нутгийн сангийн хөрөнгө оруулалт болон, аймгийн хөрөнгө оруулалтаар хийхээр эрх шилжүүлэн ирсэн хөрөнгө оруулалтын 6 ажлын сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулж, сонгон шалгаруулалтын ажлуудын 3 хурлыг зохион байгууллаа.

БОУУХМэргэжилтэн, байгаль хамгаалагч: Гашуун сухайтын төмөр замын шугамын дагуух гарц гармуудыг хийх ажлаар хамтран ажиллав.

Төмөр замын туслан гүйцэтгэгчээр ажиллаж байгаа Хатзам ХХК-тай хог хаягдлын гэрээг Долоошарзаг ОНӨААТҮГазартай байгуулуулсан.

ЕБДСургууль: Багш сурагчдаа цахим хичээлд хамрагдах ажлын бүртгэл хяналтыг тогтмол хийж ажиллаж байна. Шинэ 320 хүүхдийн барилгын ажилд тогтмол хяналт хийж зөвлөлдөн ажилласан.

Эрүүл мэндийн төв: Сумын үйлчилгээний газрууд, айл өрхүүдээр ариутгал халдваргүйжүүлэлтийг ажлыг хийлээ. Сумын нийт өрхүүд аж ахуйн нэгжүүдийн 00, бохирын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлт хийж гүйцэтгэв.

БУЛГАН СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр

Энэ сард сумын ИТХ-аас 5 тогтоол, 6 асуудал хэлэлцсэн. Сумын Засаг даргаас А захирамж 4, ЗДТГазрын даргын А тушаал 2, Б тушаал 1 тус тус гарсан байна.

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт зохион байгуулсан байдал

Сургууль дээр бөөгнөрөл үүсгэхгүйгээр Сургуулийн захирал, заах аргын 3 нэгдлийн багш, ажилчдыг тус тусад нь хүлээн авч уулзаж тухайн сард явагдах болон тулгамдаж буй асуудал бэрхшээлийн талаар асууж үүрэг чиглэл өгч ажиллалаа.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээ

Эрүүл мэндийн төвийн эмчийн үзлэгт 176 хүнийг хамруулж, түргэн тусламжийн дуудлага 6 ирж тусламжийг цаг алдалгүй түргэн шуурхай үзүүлсэн. Товлолт дархлаажуулалтын вакцинд 30 хүүхдийг хамруулаад байна. Нийт 19 жирэмсэн эхийг хянаж байна. Хамгаалах хувцас өмсөх, тайлах дарааллаар дотоодын сургалтыг 1 удаа зохион байгууллаа.

Дөрөв. Тухайн сард зохион байгуулсан шинэлэг ажил, арга хэмжээ

Шинэ төрлийн коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх бэлэн байдлын төлөвлөгөөний дагуу ЗДТГазар болон төсөвт байгууллагын албан хаагчид угтах үйлчилгээний жижүүрээ үргэлжлүүлэн ажиллаж байна. Байгууллагын цахим хаягаар өдөрт 3 дээш МСС байршуулан иргэдийг мэдээллээр хангаж байна.

Нийтийн хог цэвэрлэгээнд албан байгууллага, аж ахуй нэгж, иргэд гарч нийтийн эзэмшлийн болон хувийн эзэмшлийн талбайн хогийг цэвэрлэлээ

2020 оны 1 дүгээр сард номын санд ус алдсанаас багш, ажилчдын Төрийн албан хаагчийн хавтаст хувийн хэргүүд чийг авч шаардлага хангахгүй болсон тул бүх багш, ажилчдаар хувийн хэргийн материалыг дахин шинээр бүрдүүлж авлаа.

Тав. Багт зохион байгуулагдсан ажлууд

Багийн эргэлтээр багийн эмч нар явж иргэдэд даатгалтай эм, тариа эмнэлгийн тусламж үйлчилгээг хүргэн ажиллаа. Нийт 120 иргэн хамрагдсан байна.

Теле хичээл явагдаж байгаатай холбогдуулан 1-9-р ангийн бүх сурагчдад багш нар урьдчилан даалгавар өгч, 4-н багуудад багш, ажилчид хуваарилагдан

багийн төвүүд дээр хүүхдүүдийг эцэг эхийг хамт ирүүлж өгсөн даалгавраа шалган дүгнэж , 2020.05.18-нд дахин даалгавар өгч шалгахаар болж эцэг, эх, хүүхдүүдэд санамж, зөвлөгөө өглөө.

ГУРВАНТЭС СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн.

ИТХ: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 2020 оны 02 дугаар сарын 14-ны өдөр хуралдаж 4 асуудал хэлэлцэж баталсан байна.

Хоёр: Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт зохион байгуулсан ажил:

Сумын Засаг дарга 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Аймгийн Засаг даргатай хамтран ажиллах 2020 оны гэрээ байгуулсан бол 2020 оны 02 дугаар сарын 14-нд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хуралдаанд оролцож 15 асуудал хэлэлцэж баталсан.

Гурав: Орон нутгийн бодлого төлөвлөлт, тухайн сард зохион байгуулсан ажил, арга хэмжээ:

Сумын Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А/13 захирамжаар малын халдварт галзуу өвчний хязгаарлалтын дэглэмийг 14 хоногийн хугацаатай тогтоосон бөгөөд галзуу чононд бариулсан 3 айлын 5 малыг шатааж устгаж, ариутгаж, халдваргүйжүүлсэн мөн 3 айлын 5 малчныг галзуу өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтанд хамруулж гарын авлага тараасан. Тухайн айл өрхүүд 14 хоногийн хугацаанд малаа байнгын маллагаа, хариулгатай байлгаснаар өвчин дахин гараагүй тул сумын Засаг даргын 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/19-тоот захирамжаар хязгаарлалтын дэглэмийг цуцалсан.

2020 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А/16 өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай захирамжийг гаргаж сумыг бэлэн байдлын зэрэгт шилжин эргүүлийн хуваарь гарган холбогдох байгууллагууд өдөр бүрийн 10, 12, 14, 16, 18, 20 цагуудад мэдээ өгч ажиллаж байгаа бөгөөд уул уурхайн компаниуд, Шивээ хүрэн хилийн боомтод сумын онцгой комиссоос ажлын хэсэг ажилласан.

Улсын онцгой комиссоос ажлын хэсэг Шивээ хүрэн боомтод 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдөр ажилласан.

ДАЛАНЗАДГАД СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн.

2020 оны 04-р сарын 01-ны 17:00 цагт ИТХ-ын Тэргүүлэгчдийн 08 дугаар хурал хуралдаж дараах асуудлыг хэлэлцэн баталлаа.

1.Хуралдааны тов хойшлуулах тухай хэлэлцэн ээлжит бус Хуралдааныг тодорхойгүй хугацаагаар хойшлуулав.

Даланзадгад сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 09-р хурлыг 2020 оны 04-р сарын 10-ны 16:00 цагт ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын танхим /201/-д хуралдаж дараах асуудлыг хэлэлцэн баталлаа.

1.Даланзадгад сумын сонгуулийн хороонд ажиллах бүрэлдэхүүний нэрсийг хэлэлцэх тухай асуудлыг хэлэлцэх асуудлаас хасах санал гарган дэмжигдэж хойшлуулав.

2. Ухуулах хуудас байрлуулах байршлыг тогтоож, нийтэд мэдээлэх тухай хэлэлцэн тогтоолыг батлан дараагийн шатны байгууллагад уламжлав. Тогтоол №46

3.Төрийн шагналд зарим иргэдийг тодорхойлох тухай хэлэлцэн 4 иргэнийг төрийн шагнал тодорхойлсныг дэмжин тогтоолыг батлан дараагийн шатны байгууллагад уламжлахаар шийдвэрлэв. Тогтоол№ 47, 48, 49, 50

Сумын Засаг даргын А захирамж- 29 гарсан байна.

Даланзадгад сумын Засаг дарга бөгөөд хотын захирагчийн А/82 дугаар захирамжаар /Өндөржүүлсэн бэлэн байдлын үеийг 2020 оны 04 дүгээр сарын 30 хүртэл сунгаж сумын нутаг дэвсгэр дээр олон нийтийг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулахыг хориглолоо./

Сумын Засаг даргын санаачлага А/78 дугаар захирамжаар /Коронавирус (COVID-19)-ын халдварын тархалтын улмаас хөл хорио тогтоож, улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдал, хязгаарлалтын горимд шилжүүлсэн тул жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг эдийн засгийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бизнесийн тогтвортой байдал, ажлын байрыг хадгалах зорилгоор "Сум хөгжүүлэх сан"-гийн хөнгөлөлттэй зээлд хамрагдсан эргэн төлөлт хэвийн иргэн, аж ахуйн нэгжийн гаргасан хүсэлтийг нь үндэслэн 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 07 дугаар сарын 01-ны өдрийг хүртэл 3 сарын хугацаанд төлөгдөх зээлийн үндсэн төлбөр, хүүг түр хугацаагаар хойшлуулж төлүүлэхээр зээлийн гэрээний хуваарьт өөрчлөлт оруулах шийдвэр гаргалаа./

/Даланзадгад сумын онцгой комиссын хурлаар нутаг дэвсгэрийн хэмжээнд эрүүл мэндийн үйлчилгээнээс бусад олон нийтийн үйлчилгээний газруудад 0-18 насны хүүхэд дагуулж явж үйлчилгээ авахыг хориглолоо./

Засаг даргын Тамгын газрын даргын А тушаал-12, Б тушаал-9

2020 оны 04 сард Даланзадгад сумын ЗДТГазарт 103 албан бичиг хүлээн авснаас 35 бичиг нь хариутай. Хариутай бичгийг заасан хугацаанд шийдвэрлэсэн.

Засаг дарга болон Тамгын газраас 102 албан бичгийг холбогдох газруудад хүргүүлэн ажилласан.

Ирсэн санал, өргөдөл гомдол 33, Шийдвэрлэж хаасан 14, Хугацаандаа яваа 19 санал өргөдөл байна.

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт зохион байгуулсан байдал

2020.04.18-ны өдөр Даланзадгад хот COVID-19 урьдчилсан сэргийлэх хүрээнд албан хурал цуглаануудаа бүрэн_цахимд шилжүүлж харьяа сургууль, цэцэрлэгүүдийнхээ удирдлагуудтай цахим хурал хийж цаг үеийн мэдээлэл өгч хөл хорио тогтоосон энэ үед албан хаагчдыг эргүүл жижүүрт ажиллуулах иргэдийн маск зүүлтэд хяналт тавих, төсвийг хэмнэлтийг горимоор зарцуулан ажиллах үүрэг чиглэл өглөө.

“Аймгийн ЗДТГазар, 15 сумтай хамтран “Онлайн хурал”-ыг 2020.04.14-ний өдөр хийлээ. Онлайн хурлаар хөрөнгө оруулалт, санхүү төсөв, хяналт шинжилгээ үнэлгээ, цэрэг татлага, нийгэм боловсрол, өрх гэр бүлийн хөгжлийн жил, Covid-19 халдвараас сэргийлэх, сонгогчийн нэрсийн жагсаалт, хөрөнгө улсын үзлэг, төсвийн орлогын төлөвлөлт, биелэлт, ХАА-н талаар, Цагдаагийн газрын мэдээлэл, цаг

агаарын тойм мэдээ, Шуурхай штаб-ын мэдээ, мэдээллээр хангаж, санал солилцлоо.

“ХХААГазар, 15 сумтай хамтран “Онлайн хурал”-ыг 2020.04.15-ны өдрийн 10:00 цагт хийлээ. Онлайн хурлаар ноолуур бэлтгэлийн ажил, бог малын хээлтүүлэгч ялган суурилуулах, ээмэгжүүлэх, бэлчээр усжуулалтын талаар, түүхий эд бэлтгэлийн мэдээ, мал төллөлт, төл бойжилтын мэдээ, хүлэмж олгох журам, төлөвлөгөөний хэрэгжилт болон цаг үеийн мэдээ мэдээлэл хүргэж зарим асуудлаар ярилцаж санал солилцлоо.

2020.04.08-нд 2020 оныг “Өрх гэр бүлийг дэмжих жил”-ийн хүрээнд Өмнөговь аймгийн ХХҮГ-аас зохион байгуулсан “Нэг өрхөд нэг ажлын байр” хөтөлбөрийн сургалтад Хөдөлмөр эрхлэлт, Нийгмийн асуудал ХАБЭАХариуцсан бодлогын мэргэжилтэн, 8 багийн Нийгмийн ажилтан нар хамрагдлаа.

2020.04.10-нд “Үжин төв”, Өмнөговь аймгийн “Гэр бүл хүүхэд залуучууд”-ын хэлтэстэй хамтран зохион байгуулсан “Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг” нэгдсэн сургалтад 8 багийн Засаг дарга, Нийгмийн ажилтан нар хамрагдлаа.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлт, тухайн сард зохион байгуулсан ажил, арга хэмжээ

Тусгай үүргийн онгоц, орон нутгийн боомтуудаар нэвтэрсэн болон бусад шалтгаанаар тусгаарлах байранд ажиглалтад байсан /8/ иргэнийг үргэлжлүүлэн гэрийн ажиглалтад хянахтай холбогдуулан хяналт тавих албан хаагчдын нэрсийг жагсаалтаар баталж, иргэний гар утсанд нь байршил тодорхойлогч аппликейшнийг суулгаж, байршил тогтоогчоор болон эргүүлийн хяналтаар 08:00-20:00 цагийн хооронд хянаж байхыг сумын Онцгой комиссын орлогч дарга /Ж.Даваахүү/, 20:00-08:00 цагийн хооронд хяналт тавихыг Цагдаагийн газрын Нийтийн хэв журмыг хамгаалах тасгийн дарга дэд хурандаа /Ө.Батжаргал/-д, гэрийн ажиглалтад байгаа иргэд шаардлагатай үед зөвлөгөө авч, биеийн халуунаа өдөрт 2 удаа хэмжиж утсаар болон цахимаар өрхийн эрүүл мэндийн төвөөс томилогдсон эмчдээ хянуулахыг зөвлөж, өдөр бүрийн 10:00, 18:00 цагуудад иргэний мэдээг нэгтгэн аймгийн шуурхай штабд мэдээлэн ажиллаж байна.

Улсын нөөцөөс сумдад хувиарласан 500 боодол өвс, 250 шуудай хивгэн тэжээлийг аймгийн нөөцийн газраас хүлээн авч, малчдад 2020.03.26-27-ны өдрүүдэд малчдад олголоо.

Орон нутгийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Ахмад настны ажлын байрыг нэмэгдүүлэх”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг нэмэгдүүлэх”, “Өрх толгойлсон эцэг эхийн ажлын байрыг нэмэгдүүлэх” төслийг хүлээн авч эрэмбэлэн сумын амьжиргаа дэмжих зөвлөлөөр хэлэлцүүлж, шалгаруулах шатны дээд байгууллагад хүргүүлээ.

2021 онд ОХНС-н хөрөнгөөр хийгдэх ажлын саналыг иргэдээс авах саналыг иргэдээс <https://docs.google.com/forms/> цахимаар авч эхэллээ.

15-р байрны оршин суугчидтай уулзаж байрны гадна засвар тохижилтын ажлын зураг төсвийн эскиз зурган дээр санал авч зураг төсвийн ажилд тусган ажиллаж байна.

Аймгийн засаг даргын а/65 дугаар захирамжаар эрх шилжүүлсэн 4 нэр төрлийн ажлын тендерийг цахимаар бүрэн зарласан. “Сумын төв доторх авто зам, авто зогсоол, явган хүний зам, гэрэлтүүлгийг барьж байгуулах /Улаанбаатар

чиглэлийн зам - Соёл амралтын хүрээлэн хүртэлх 4.22 км/” ажлын тендерийн үр дүн гарч Таны зам ХХК гүйцэтгэгчээр шалгарсан байна.

Сумын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 27 нэр төрлийн ажлаас 12 нэр төрлийн ажлын үнэлгээний хороог байгуулж, 9 нэр төрлийн ажлын тендерийг цахимаар зарласан. Үүнээс 4 нэр төрлийн ажлын тендер бүрэн дуусч гүйцэтгэгч шалгарсан байна.

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх 3 нэр төрлийн ажлаас 1 нэр төрлийн ажлын тендерийг зарлаж, компани оролцоогүй учир дахин зарлаад байна. Бусад 2 нэр төрлийн арга хэмжээ корона вирусийн халдвартай холбоотойгоор орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт тасрах эрсдэл үүссэн учир түр хойшлуулсан байна.

Сумын харьяа улсын төсвийн 5 сургууль, 10 цэцэрлэгийн хоол, үдийн цайны 14 нэр төрлийн тендерийг цахимаар зарлаж, үр дүн гарч дууссан.

Сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 56.1 хувьтай байна.

Суманд хэрэгжүүлэх “Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө”-г Монгол улсын хэмжээнд анхлан хийж, 10 н томилгоот нэгж, 1 орон нутгийн отрядийг байгуулав.

Даланзадгад сумын онцгой комисст: Нийгмийн хариуцлагынхаа хүрээнд Даланзадгад хотод үйл ажиллагаа явуулдаг “Тотал Дистрибушин” ХХК-ний хамт олон Шинэ Коронавирус /COVID-19/-ын халдвараас урьдчилан сэргийлэх ажилд дэмжлэг үзүүлж 800 л буюу 1.520.000 төгрөгийн үнэ бүхий шатахууны толаныг хандивлалаа. Уг хандивын шатахууны талоныг өндөржүүлсэн бэлэн байдлын үед иргэдийн эрүүл мэндийн төлөө ажиллаж байгаа Шим билэг, Өнө-Орших, Энхийн хүслэн өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хүлээлгэн өглөө.

Даланзадгад сумын газар тариалан эрхлэгч Ц.Оюунцэцэг 50 ширхэг амны хаалт /маск/-ыг хүлээлгэн өглөө.

Дөрөв. Тухайн сард зохион байгуулсан шинэлэг ажил, арга хэмжээ:

Даланзадгад сумын Онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 07 дугаар хурлын шийдвэр, Засаг даргын А/67 тоот захирамжийн дагуу 2020 оны 03 дугаар сарын 29-ний өдөр 06:00-22:00 цаг хүртэл 57 км засмал зам болон шороон зам, нийтийн эзэмшлийн талбайд ариутгал, халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулж, сумын хэмжээнд 58,4 км засмал зам, 6,9 км дугуйн зам, гэр хорооллын 229 гудамж, 340 км шороон зам нийт 405,3 км нийтийн эзэмшлийн зам талбайд 200 кг ариутгалын /НI COP/-ыг ашиглан 200 тн уусмал бэлтгэн ариутгал, халдваргүйтгэлийг ЗДТГ-ын 58 албан хаагчид хуваарьт талбайд хяналт тавьж ажиллаа. Сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс 7580000 төгрөг зарцууллаа.

Даланзадгад сумын ЗДТГазар, МҮЧЗХолбооны гишүүн, хүүхдийн зохиолч С.Гантогтохтой хамтран зохиогчийн МӨНДӨӨЛЭЙ цуврал номын шүлгээр зохион байгуулсан "АВЪЯАСЛАГ МӨНДӨӨЛЭЙ" уран уншлагын цахим уралдааныг амжилттай зохион байгуулж, уралдаанд 89 хүүхэд оролцож байр эзэлсэн хүүхдүүдэд шагналыг гардууллаа.

Цэмцгэр_Даланзадгадын төлөө хамтдаа уриан дор Даланзадгад сумын Засаг даргын Тамгын газрын нийт 68 албан хаагчид Шинэ суурьшлын бүсийн 3,1 километр авто зам, 3,1 километр явган хүний замыг шүүрдэж, орчны хог хаягдал, Даланзадгадаас Гурвансайхан нисэх буудал хүртэл авто зам, зүүн тийш Малчны

хороолол, Малчны хорооллоос урагш Үдэлт угталтын хаалга хүртэлх нийтийн эзэмшлийн талбайн хог хаягдлыг цэвэрлэлээ.

2019 онд хөнгөлөлттэй үнээр Хүлэмж авсан 35 газар тариалан эрхлэгчдэд газар тариалан хариуцсан мэргэжилтэн мэргэжлийн агрономичтой хамтран “Ойн ангийн хүлэмжийн цогцолборт” хаврын тариалалттай холбоотой мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

Гарал үүслийн 4 гэрчилгээнд баталгаажуулалт хийгдлээ.

Мал эмнэлгийн газрын шуурхай жижүүрт өдөр бүр мэдээлэл өгч, 17 дуудлага хүлээн авч, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 6570 ишгэнд шөвөг ярын вакцин хийгдээд байна.

Сумын хэмжээнд том малын хорогдлын мэдээг нэгтгэн авч Мал эмнэлгийн газарт мэдээлэн 326 том малын хорогдолтой байна.

Тав. Багт зохион байгуулагдсан ажлууд

Сумын Засаг даргын 2020 оны А/82, А/84 дүгээр захирамжийн хэрэгжилтийг сумын нутаг дэвсгэр, 8 багийн хэмжээнд хэрхэн хэрэгжиж байгаа эсэх талаар ЗДТГ-ын албан хаагчид 3 өдөр эргүүл, шалгалт, хяналтын ажлыг зохион байгууллаа.

МАНДАЛ-ОВОО СУМ

Нэг .Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр:

Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол 4 гарсан байна. /Сонгуулийн сурталчилгааны ухуулах болон зурагт хуудсыг байрлуулах байршлыг тогтоох тухай, Сонгуулийн тойрог байгуулах, тойрогт ногдох мандатын тоог хувиарлах тухай/

Сумын Засаг даргын захирамж 21 гарсан. /Коронавирусийн халдаврын үед эмнэлэг дэлгэх, тусгаарлах байрны зориулалтаар ашиглах тухай, Мод тарих сарын аяныг зохион байгуулах тухай/

Тамгын газрын даргын тушаал 3

Хоёр. Хурал, зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт:

Засаг даргын Тамгын газрын дотоодын шуурхай хурал 1, албан байгууллагын дарга, эрхлэгчдийн хурал цуглааныг 1 удаа зохион байгуулж, цаг үеийн тулгамдсан асуудлыг хэлэлцэж шийдвэрлэв.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил, арга хэмжээ:

Сонгуульд ажиллах төрийн албан хаагчдын судалгаа мэдээлэлийг аймагт хүргүүлэв.

Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж аймгийн ОБГ-т хүргүүлэв.

Сумын стратеги үнэлгээ хийв.

Аймгаас эрх шилжин ирсэн Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн тохижилтын ажлын гэрээг Ихэр сайхан уул ХХК-тай байгуулж ажил нь эхлэв.

Цахимаар 3 удаа дотоодын сургалтыг зохион байгуулж 61 албан хаагч хамрагдав.

Баянхошуу багийн төвийн барилгын ажлыг гүйцэтгэх ажлын гэрээг Говийн очир огтлогч ХХК-тай байгуулав.

Дотуур байрны засварын ажлын гэрээг Аз билэгтэй ХХК-тай байгуулж дотуур байрыг засварт бэлтгэн суллав.

Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг боловсруулан, бэлтгэл үүрэгтнүүдийг томилгоожуулав.

Нийгмийн эмзэг бүлэгт хоол тэжээлийн дэмжлэг үзүүлэх барааны нийлүүлэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороо байгуулав.

Иргэдэд шинэ коронавирусийн халдварас сэргийлэх зөвлөмжийг цахим хуудас, мэдээллийн самбар, узель, урсдаг самбар, гарын авлагаар дамжуулан тогтмол хүргэж байна.

Сумын Шуурхай штабаас үйлчилгээ үзүүлж байгаа ААН, байгууллагуудаар болон гадуур эргүүл хяналт хийж амны хаалтны хэрэглээ, ариутгал цэвэрлэгээ, гар ариутгах угаах нөхцөл боломжийг бүрдүүлсэн зэрэгт хяналт хийж ажиллаж байна.

Цэргийн дүйцүүлэх албыг биеэр хаах 3 иргэний гэрээг байгуулав.

Нийгмийн эмзэг бүлэгт хоол тэжээлийн дэмжлэг үзүүлэх барааны нийлүүлэгчийг сонгон шалгаруулж, Өлзийт хонгорхайрхан ХХК-д гэрээ байгуулах эрх олгож, гэрээг байгуулав.

Ажиглах болон тусгаарлах байрны бэлэн байдлыг хангаж 3,3 сая төгрөгний хамгаалалтын хувцас, ариугалын бодис, амны хаалт, халуун хэмжигч зэрэг шаардлагатай бараа материалыг татан авав.

Архи сонтууруулах ундаа худалдан борлуулах зөвшөөрөл бүхий 6 ААН-д хяналт шалгалт хийж тайланг ХЭЗХ-т хүргүүлэв.

Цахимаар 8 өргөдөл бүртгэгдэв.

Ашиг сонирхлын зөрчлийн талаарх 44 мэдэгдэл тайлбарыг хүлээн авч бүртгэв.

Сумын Эрүүл мэндийн төвөөс 2 удаа 115 объектийн 6239 м кв талбайд ариутгал хийв.

Мэргэжлийн байгууллага болох аймгийн Хүслэн хийморь ХХК-ыг сумандаа авчирч 25 объектод ариутгал, халдваргүйтгэл хийлгэв.

Говийн оюу ХДС-н квотын гэрээ байгуулж, төсөл хөтөлбөрийг хүлээн авч байна.

Аймгийн ЗДТГ-с зохион байгуулсан онлайн хуралд 30 албан хаагч оролцов.

Аймгийн Орон нутгийн өмчийн газрын үзлэг хяналтын мөрөөр бүх байгууллага зөрчил дутагдлаа засах арга хэмжээг зохион байгуулж тайлагнав.

Эрүүл мэндийн төвийн дотоодын шуурхай хурлыг 2 удаа зохион байгуулж, Коронавирусийн үеийн бэлэн байдлыг хангах үүднээс эмнэлэгийн 18 ажилтанд 1 удаа Коронавирусын халдвараас хамгаалах, урьдчилан сэргийлэх талаар сургалт хийв.

ЭМГ-аас зохион байгуулсан Коронавирусын бэлэн байдлыг хангаж ажиллах урьдчилан сэргийлэх, тэмбүүг устгая төлөвлөгөөний дагуу, дархлаажуулалт, хяналт үнэлгээ, тохиолдолд суурилсан теле хуралд 4 удаа нийт давхардсан тоогоор 68 эмч, мэргэжилтэн хамрагдав.

0-5 насны хүүхдийн гэрийн эргэлт 5, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гэрийн эргэлтийг 9 удаа хийж зөвлөгөө өгч ажилласанаар өвчлөл, дуудлага бага байна.

2020 оны татварын орлогын гүйцэтгэлийн журмыг батлагдсан маягтын дагуу төрийн сантайгаа баталгаажуулан 2020 оны 04 дугаар сарын 07-нд судалгааг гарган холбогдох газарт нь өгсөн.

Татвар хураалтын үйл ажиллагааны процессийн мэдээг 4 сарын 5-ны дотор холбогдох газарт хүргүүлсэн.

ЗДТГ-ын албан хаагчдад Татварын шинэчилсэн хуулийн талаар материал бэлдэн дотоодын сургалтыг цахимаар зохион байгуулав

Галт зэвсэгийн албан татвар дээр давхар үүссэн нэхэмжлэхийг харъяа байцаагчтайгаа холбогдон засварласан.

ХХОАТ-ын хөнгөлөлт авах 11 иргэний 2630837,89 төгрөг иргэн бүрийн дансанд 4-р сарын 9-нд шилжин орсон. Авто зам ашигласны татвар үүсээгүй авто машины ногдолыг хийж дуусгасан.

Нийгмийн халамжийн чиглэлээр: 2020 оны 4 сард нийгмийн халамжийн тэтгэвэрт 31 иргэн 5.815.480 төгрөг, нийгмийн халамжийн тэтгэмжинд 50 иргэн 4.985.840 төгрөг, алдар цолтой ахмад настан 1 иргэнд 200000 төгрөг, жирэмсэн эхийн тэтгэмжид 15 иргэн 609,970 төгрөг, цалинтай эхийн тэтгэмж 86 иргэнд 4.454,620 төг нийт 183 иргэнд 16.065.910 мян төгрөгний санхүүжилт хийгдлээ.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж буй 12 өрхөд 776.000 төгрөгний эрхийн бичгийн олголт хийгдлээ.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр: ХЭДС-с зарлагдсан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 35-с дээш насны иргэний ажлын байрыг дэмжих төсөл хөтөлбөрүүд зарлагдаж иргэдэд төсөл хөтөлбөрийн зар мэдээ мэдээлэл хүргэж иргэдээс ирсэн төслийг хүлээн авч ХБИргэний 3 төсөл, Ахмад настны 1 төсөл, 35-с дээш насны иргэний ажлын байрыг дэмжих 3 төсөл ахмадын зөвлөх үйлчилгээний 2 төсөл нийт 9 төслийг 4 сарын бнд АДЗөвлөлөөр хэлэлцэн эрэмбэлж ХХҮГ-т хүргүүллээ. Мөн Бүлгийн зохион байгуулалттай ногоо тариалах болон нийтийг хамарсан ажлын төсөл хөтөлбөр зарлагдаж мэдээллийг хүргэн ажиллаж байна. Малжуулах төсөл хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй 8 өрхийн судалгааг гаргаж ХХҮГ-т хүргүүллээ.

ЕБС-д багшийн 2 орон тоонд 2 ажилгүй иргэн ажилд зуучлагдсан.

ХАБЭА-2020 сарын аян 4 сарын 1-ээс 5 сарын 1-ны хооронд зарлагдаж Аяны төлөвлөгөө гарган ААН, байгууллагат цахимаар мэдээ мэдээлэл хүргэн ажиллаж байна.

Иргэний улсын бүртгэлийн төрсний бүртгэлд шинээр төрсөн 1 хүүхэд бүртгэж төрсний гэрчилгээ олгосон, ургийн овог эцэг/эх/-ийн нэр, нэр өөрчлөлтийн бүртгэлд 1 иргэн бүртгүүлсэн. мөн 16 нас хүрч шинээр иргэний үнэмлэх 3 иргэн, 25, 45 насны сунгалт 1 иргэний тус тус биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд бүртгүүлсэн.

Монгол цэргийн өдрийг тохиолдуулан “Аавтайгаа хамт”, Инээдмийн баярыг угтан “Зүгээр л инээмсэглэ” гэрэл зургийн уралдаан, “Элэг хөшлөө” онигооны уралдааныг тус тус цахимаар зохион байгуулж нийт 63 иргэн хамрагдсанаас 9 иргэнийг шалгаруулан шагнав.

Дөрөв: Багт хийгдсэн ажлууд:

3 багийн хөрөнгийг баг дээр нь очин тоолж, бүртгэл хяналтыг сайжруулах арга хэмжээг зохион байгуулав.

Өтгөн, багийн 4 өрхийн 11 иргэн, Баянхошуу багийн 5 айлын 14 малчинд явуулын номын сангийн үйлчилгээ үзүүлж нийт 9 өрхийн 25 иргэн хамрагдаж сүүлийн үеийн ном зохиолтой танилцсан нь тэдний эрэлт хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ болов.

НОЁН СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн.

Сумын Засаг даргаас энэ сард 7 захирамж гарган ажилласан. /Онцгой байдлын зардалд дэмжлэг үзүүлнэх тухай А/52, Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг зохион байгуулах тухай А/53, Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай А/54, 2020 оны төсвийн сар, улирлын хуваарь батлах тухай А/55 , Аян өрнүүлэхс А/56 , Хаягийн мэдээлэл шалгах , засварлах , зэрэгцүүлсэн хаягийн мэдээлэл үүсгэх ажлын хэсэг байгуулах тухай А/57, Гэрээ байгуулж ажил гүйцэтгүүлэх тухай А/58/

Хоёр . Хурал, зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт:

Хөдөлмөр халамж үйлчилгээний газраас нэг өрх нэг ажлын байр цахим сургалт хийж нийгмийн бодлогын мэргэжилтэн , халамж үйлчилгээний мэргэжилтэн нар оролцсон.

Аймгийн нэгж агентлагаас хийсэн цахим хуралд хамаарал бүхий дарга албан хаагчид оролцсон .

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын урлагийн сэтгэл заслын АРТ ТЕРАПИ сургалтад нийгмийн бодлогын мэргэжилтэн, сургуулийн нийгмийн ажилтан нар оролцсон.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил, арга хэмжээ:

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө 1083392020 төгрөгөөр “Уурын зуухны барилга барьж шинэ зуух суурилуулах ажлыг “Шүтээн эрдэнэ” ХХК-тай гэрээ байгуулж гарын үсэг зурлаа.

Сумын хамтын хорооны 20 сая төгрөгийн хөрөнгөөр “Баянбогдын оргил” ХХК сумын камержуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Сумын онцгой комисс 4 удаа хуралдсан. Аймгийн онцгой байдлын газрын дарга Л. Баярсайхан , Эрүүл мэндийн газар удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтсийн дарга М.Цэндсүрэн нар СДЭ-н тусгаарлах эмнэлэгтэй танилцаж ажилласан.

Сумын хяналт шинжилгээ үнэлгээний нэгж төсөвт байгууллагуудаар хяналт хийж ажиллав. Байгууллагууд “маскаа тайлах болоогүй” аянд нэгдэж мэдээллээ цахим орчинд байршуулсан.

НОМГОН СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн:

Сумын Засаг даргын “А” захирамж 5, Тамгын газрын даргын “А” тушаал 2 тус тус гарсан байна.

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт:

Тамгын газрын албан хаагчдын болон албан байгууллагуудын дарга, эрхлэгч нарын “Шуурхай хурал”-ыг 1 удаа хуралдаж, удирдлагуудаас цаг үеийн мэдээлэл өгч, үйл ажиллагаатай нь танилцаж, санал солилцлоо.

Гэр бүл хүүхэд залуучуудийн хөгжлийн газраас “Гэр бүл хүүхдийн хүчирхийллийг бууруулахад төрийн албан хаагчийн үүрэг, оролцоо, хариуцлага тооцох нь” чадавхжуулах сургалтанд байгууллагын дарга, эрхлэгч төрийн албан хаагч 14 хүн хамрагдсан.

Өмнөговь аймгийн ЗДТГазраас зохион байгуулсан “Цахим хурал”-д бүх албан байгууллагын дарга, эрхлэгч болон ЗДТГазрын төрийн албан хаагчид нийт 25 хүн хамрагдаж мэдээ мэдээлэлтэй танилцлаа.

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн Квотын санхүүжилтийн гэрээ байгуулагдсан.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил, арга хэмжээ:

Улсын онцгой комиссын шийдвэрийн дагуу шинэ төрлийн коронавирусын эсрэг өндөржүүлсэн бэлэн байдалд хяналтын таван постын хоолны зардалд 790000 төгрөгийг шийдвэрлэлээ.

Сумын хэмжээнд 2020 онд Орон нутгийн хөгжлийн сангаас Засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоолын 02 дугаар хавсралтаар батлагдсан жагсаалтад заасан өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний зардалд 32436000 төгрөгийг тус бүр 3 аж ахуй нэгжүүдэд хувиарлан ажиллаж байна.

Номгон сумын Эрүүл мэндийн төвийн цэвэр, бохир, дулаан, цахилгааны агааржуулт засварын зураг, төсөв хийлгэх ажлын гүйцэтгэлийг ажлын хэсэг хүлээн авлаа.

Сумын төвийн золбин нохой, муур устгах ажлыг 04 дүгээр саын 09 – 11-ийг хүртэл зохион байгуулан 98 нохой, 15 муур устгаж, ариутгалын ажилд 2000000 төгрөг шийдвэрлэлээ.

Иргэний бүртгэл: Нийт шинээр төрсөн 15 хүүхэд, овог, нэр өөрчлөлт 2, гэрлэлт 2, нас баралт 2, иргэний үнэмлэх захиалалт 20 тус тус бүртгэгдсэн байна.

Хөдөлмөр, халамж: Халамжийн сангаас зарлагдаж буй төсөл хөтөлбөрүүдийг иргэд олон нийтэд ил тод зарлаж, нийт иргэдийн төслийг аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт шийдвэрлүүлэхээр хүргүүллээ.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны нээлтийг онлайнаар нээсэн.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид 280 иргэнд 22,9 сая төгрөгийг олгоод байна.

“Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ”-г 8 өрхөд сардаа 672000 мянган төгрөгийн хүнсний хөнгөлөлтийн олголт хийсэн.

Байгаль орчин: 03 сарын 17-ноос 4 сарын 17-нийг хүртэл Эмгэнбулаг багийн Элстийн хошуунд хууль бусаар алт олборлосон иргэдтэй ажиллаж, зөрчлийн тухай хуулиар торгон шийвэрлэх арга хэмжээг 5 иргэнд авлаа.

Ерөнхий боловсролын сургууль: Аймгийн Боловсрол, Соёл урлагийн газрын А/90 албан тоотын дагуу хамран сургах тойргийн сурагчдыг тоглоомын талбай болон олон нийтийн газар бөөгнөрөл үүсэхээс урьдчилан сэргийлж, хяналт тавин ажиллаж байна.

Багш нар цахимаар хичээл бэлдэж эцэг эх болон сурагчидтай холбогдон ажиллаж байна.

Цэцэрлэг: Сургуулийн өмнөх боловсролын бүлгийн багш нар 1 - 3 сарын хичээлийн хэрэглэгдэхүүнийг эцэг эхэд буцаан олголоо.

Дөрөв. Тухайн сард зохион байгуулсан

Эрүүл мэндийн байгууллага, Мал эмнэлгийн тасагтай хамтарч байгууллага, аж ахуйн нэгжүүд байгууллагын гадна, дотно ариутгалын ажил хийгдлээ.

Соёл, спорт цогцолбор шинэ барилгын нээлтийн үйл ажиллагаа цахим хэлбэрээр зохион байгуулагдсан.

Тав. Багт хийгдсэн ажлууд: Өвөлжөө бууцны кадастрын зургийн ажил 80 хувьтай хийгдэж байна.

Богт багт Орон нутгийн хөгжлийн сангаас хийгдэх 44 сая төгрөгийн шинэ соёлын төвийн тендерийн үйл ажиллагаандаа явагдаж байна.

СЭВРЭЙ СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн.

Сумын Засаг даргаас 18 захирамж боловсруулагдан гарсан.

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт,

Сумын хэмжээнд “Хүмүүн бичигтэн Сэврэйчүүд” аянгыг зохион байгуулж ЕБС-ийн Монгол хэлний багштай хамтран 11 удаагийн цахим хичээлийг зохион байгуулж сумын нийт төрийн албан хаагчдыг үндэсний бичгийн сургалтанд хамруулсан.

Баг байгууллагын дарга эрхлэгч нар болон ЗДТГ-ын албан хаагчид аймгийн удирдлагуудтай цахим хурал хийсэн хуралд нийт 31 хүн хамрагдсан.

ЕБС, Цэцэрлэг, Соёлын төв гэсэн байгууллагууд Боловсрол соёлын урлагын газрын шалгалтанд хамрагдсан.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил, арга хэмжээ

ОНХС-ийн хөрөнгөөр Орон нутгийн мэдээллийн хэрэгслийн тоног төхөөрөмж үйлчилгээг хийх “Сэврэй хишиг угалз” ХХК шалгарч ажлыг гүйцэтгэж байна.

Ерөнхий боловсролын сургууль /цэцэрлэг / ийг авто машинтай болгох энэ ажлыг цахимаар Tender.gov.mn сайтаар зохион байгуулж Уаз мега ххк нь 37.400.000 төгрөгөөр гүйцэтгэж пургон авто машин нийлүүлсэн.

Нийтийн худалдааны төв үйлчилгээний цэг байгуулах зураг төсөв боловсруулах /нүдэн булаг сургалтын төв дээрх 2 контейнийг тохижуулах 1 эмнэлэг 2 гар урлалын бүтээгдэхүүн борлуулах цэг / ажлыг шууд гэрээ хийж Б.Мягмар ахлагчтай иргэдийн бүлэгтэй гэрээ байгуулж уг ажлыг гүйцэтгэж дууссан.

Багийн дарга нар хөдөөгийн бүх малчин өрхөөр явж цаг үеийн мэдээлэл хүргэж Орон нутгийн хөгжлийн сангийн магт-1 тарааж ажилласан.

Сумын амжиргаа дэмжих зөвлөл хуралдаж иргэдээс ирсэн 7 төслийг хэлэлцэж Хөдөлмөр халамж үйлчилгээний газарт хүргүүлсэн.

“Говийн оюу” хөгжлийг дэмжих сантай 2020 онд хамтран ажиллах гэрээ байгуулсан.

Сумын хэмжээнд төсөвт 6 ОНӨ-т 3 байгууллагын нийт 9 байгууллагат ОНӨГазрын шалгалт ирж бүх эд хөрөнгийг нүдээр үзэн тоолж шалгаад цаашид хэрэгжүүлэх ажил арга хэмжээг зөвлөн явсны дагуу байгууллага бүрт үүрэг даалагавар өгч хөрөнгийг картжуулах коджуулах, эзэнжүүлэх бүртгэлт тусгаагүй хөрөнгийг бүртгэлд тусгах зэрэг ажлыг хийж гүйцэтгэж байна.

Сумын төвд нийтийн эзэмшлийн гудамж талбай цэврэлгээг хийж ариутгал халдваржүүлэх ажлыг суманд үйл ажиллагаа явуулж байгаа 2 мал эмнэлэгтэй хамтран зохион байгуулсан.

Коронавирусын дэгдэлтээс сэргийлэх бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулан тусгаарлах өрөөг стандартын дагуу тохижуулсан байна.бэлэн байдлын үнэлгээ хийж үзэхэд 81,5 %-тай байна

Короно вирусээс хамгаалах санамж мэдээлэлийг цахимаар иргэдэд тогтмол хүргэж ажиллаж байна.

Цэцэрлэг: Багш нар нийт 7 видео хичээлийг 51 хүүхдэд хүргэж ажиллаж байна. Мөн өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө зөвлөмжийг өгч ажиллаж байна.

Анги танхим, гадаа талбай, хогийн цэгийг цэвэрлэн ариутган ажиллаж байна. Теле хичээлийг буулгаж хэрэглэгдхүүнийг хийн үзэсгэлэн гаргалаа. Мөн 17 хүүхдүүдээр явж хичээлийг хамтран орж давтсан байна.

Эрүүл мэндийн төв: Коронавирусын дэгдэлтээс сэргийлэх “Маскаа зүүцгээ” аяныг өрнүүлэн 6 албан байгууллага 18 дэлгүүрээр явж маск зүүх,гар угаах, ариутгал цэвэрлэгээ, зөрчлийн хуулийн талаар зөвлөмж өгч уриалгыг мэдээллийн самбар болон хаалганд байршуулан ажилласан байна.

ААН,албан газар, 18 дэлгүүр, 95 айл өрхийн халдваргүйтлийг зөвлөмжийн дагуу хийлгэн хяналтыг тавьж ажилласан .

ЭМТ-ийн FB хуудсанд Covid 19 халдвараас сэргийлэх, “маскаа зүүцгээ” уриалгыг байршуулсан

Өндөржүүлсэн бэлэн байдлын үед хариуцлагатай жижүүр хуваарийн дагуу ажиллан мэдээ мэдээллийг цаг хугацаанд шуурхай дамжуулан ажиллалаа.

Эмнэлгийн эмч ажилчдад халдвараас сэргийлэх, хамгаалах хувцас хэрэгслийг өмсөх тайлах дараалалыг зааж сурган хүн нэг бүрээс хяналтын хуудсаар хянасан байна.

20 ахмад настанд гэрийн эргэлт хийж асаргаа шаардлагатай 11 ахмадад гэрт нь асаргаа сувилгаа хийсэн

Соёлын төв: 4 дүгээр сарын 6-ны өдрөөс 4 дүгээр сарын 18-ныг хүртэл хөрөнгийн тооллого, коджуулалт зэргийг хийж цэгцэллээ.

Номын сангаас номын богцыг айл өрхөөдүүр аялуулж байна. Цахим уншлагыг тогтмол явуулж байна. Хаврын эгшиглэн теле концертын бэлтгэл ажил хийгдэж байна. Соёлын биет бус өв тээгчдийн өвийг баримтжуулах ажил хийгдэж эхэлсэн. Видео цахим хэлбэрээр ажил зохион байгуулах программ хангамжийг сайжруулсан.

Нийгмийн халамж:

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр: Хөдөлмөр эрхлэлтийн албанд 2 иргэнийг шинээр бүртгэн ажилласан.

Орон нутгийн болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтээр хэрэгжих төслүүд зарлагдан сумын сонин болон мэдээ мэдээллийн хэрэгсэл Мөрөөдлийн FM-ээр 3-н багийн засаг дарга нар иргэдэд мэдээллийг орон нутгийн санхүүжилтийн төсөлд 10 ,хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөлд 10 нийт 20 төслийг хүлээн аван АДЗөвлөлийн хурлаар хэлэлцэн дээд байгууллагад хүргэн ажилласан.

Нийгмийн халамжийн чиглэлээр: Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг 25 иргэнд 4.6 сая төгрөг, амьжиргааг дэмжих мөнгөн тусламжийг 32 иргэн 2,7 сая, байнгын асаргаа халамж шаардлагатай 7 хүүхдэд 1,2сая , жирэмсэн 15 эхэд 0.5 сая төгрөг , цалинтай ээж хөтөлбөрт 104 эхийг хамруулан 5,3 сая төгрөгний санхүүжилтыг тус тус олгон ажилласан.

Аймгийн халамжийн газраас (COVID-19) өвчин гарсантай холбогдуулан маск , витамин, гар ариутгагчыг 30 ахмад настанд олгон ажилласан.

Амьжиргаа дэмжих зөвлөл: АДЗөвлөлийн хурлаар орон нутгийн болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрт хамрагдах иргэдийн төсөл болон шинээр байнгын асаргааны тэтгэмжинд хамрагдах хүсэлт гаргасан иргэдийн бичиг баримтыг хүлээн аван хурлаар хэлэлцэн шийдвэрлэн ажилласан.

Архив, албан бичиг хэрэг хөтлөлтийн чиглэлээр: Жирэмсэн 10 эх, цалинтай ээж хөтөлбөрт хамрагдах 4 иргэн, байнгын асаргаа шаардлагатай иргэний тэтгэмжинд хамрагдах 2 иргэний баримт бичгийг шинээр бүрдүүлэн хувийн хэрэг нээн ажилласан .

Ажлын төлөвлөлт, хэрэгжилт, үр дүнгийн талаар: Шинээр хүүхдийн мөнгөн тэтгэмжинд хамрагдах хүсэлт гаргасан 2 өрхийн мэдээллийг дээд байгууллагад уламжлан ажилласан.

Хөдөө аж ахуйн тасаг: Газар тариалгийн салбарт :Төмсний үрийн захиалга нийт 420 кг, үрсэлгээний захиалга 1210 кг авч аймгийн хүлэмжийн аж ахуйд хүргүүлж үрийг захиалсан иргэдэд хүргүүлсэн

Сум хөгжүүлэх сангийн 4-р сарын 06-нд төсөл сонгон шалгаруулах зөвлөл хуралдаж 9 төсөлд 81,3 сая төгрөгний санхүүжилт олгохоор шийдвэрлэсэн.

Мал аж ахуйн салбарт: 2019 онд төлөөр өссөн ботгоний урамшуулалд 93 өрхөд 2,210,000 мянган төгрөг малчид олгогдсон

Бүйлсэн багт говь гурван сайхан үүлдэрийн 150 ямаанд үзлэг ангилалт хийж ноолуурын дээж, гарц тодорхойлолт хийсэн.

4-р сарын 15-ны байдлаар 12085 төл бойжиж байна

Байгаль орчин:

3 сарын 27-нд төвийн албан байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийг 50 метрийн дотор хог хаягдлаа түүж цэвэрлэх мэдэгдэл хүргүүлж, цэвэрлэгээнд гаргасан. Дараагаар нь Мал эмнэлгээс гудамж талбайн ариутгалын ажил хийгдсэн.

4 сарын 17-нд Цагдаагийн хэсэгтэй хамтран Хоолт, Бүйлсэн багийн нутгаар хяналт шалгалтын ажил зохион байгуулж, 10 машиныг сатуулсан.

Хаврын мод тарилтанд шаардлагатай тарьц суулгацын захиалгыг иргэдээс авч БОАЖГазарт хүргүүлсэн. Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн усалгаа хийж, мод тарих ажлын бэлтгэл хийж байна.

Газрын харилцаа: Газрын кадастрын цахим мэдээллийн санд иргэн, аж ахуйн нэгж байгууллагын төлбөр бодож гэрээг дүгнэн байгуулсан.

Хилийн цэсийн гадна олгогдсон нэгж талбарын судалгааг гарган ГХБХБГазарт хүргүүлсэн.

Дулааны шугамын транс тогтоох тухай А/54 тоот захирамж гаргасан. Газар эзэмшигч аж ахуйн нэгжийн хүсэлтийн дагуу А/57 тоот захирамж гаргасан.

Нийгмийн даатгал: Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд 141 иргэн хамрагдаж 17272,4 мянган төгрөг,эрүүл мэндийн даатгалд 96 иргэн хамрагдаж 3581,2 мянган төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлэн ажилласан.

Тэтгэврийн даатгалын сангаас Өндөр нас тахир дутуу тэжээгчээ алдсаны тэтгэврийг ХААН банкаар 260 иргэнд 372 658,8 сая төгрөг, Төрийн банкаар 20 иргэнд 26808,4 сая төгрөг,1991-1994 онуудад хөнгөлөлттэй нөхцлөөр тэтгэвэрт гарсан 32-н ахмадад 6550 000 -ийн тэтгэврийг олгосон.Шинээр өндөр насны тэтгэвэрт 1 иргэн гарч тэтгэвэр тэтгэмжиндээ хамрагдсан.

Тэтгэмжийн даатгалын сангаас жирэмсний тэтгэмжийг 1 иргэнд 680,1 мянган төгрөгийн тэтгэмжийг олгосон.

Ажилгүйдлийн даатгалын сангаас 2 иргэнд 1845,0 мянган төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг тус тус олгосон.

Татварын улсын байцаагч: Татварын ерөнхий газраас явуулж байгаа онлайн болон бусад сургалт сурталчилгааны мэдээллийг 98 иргэн болон аж ахуйн нэгжид түгээн ажиллаж байна. Мөн Татварын поргарамм шинчлэгдсэнтэй холбоотой иргэдийн мэдээллийг засах шинээр код авч бүртгүүлэх ажилд 42 иргэнийн мэдээллийг шинэчлээд байна.

Улсын төсөвт 2,8 сая төгрөг төвлөрүүлэхээс 2,4 сая төгрөг төвлөрүүлж 86 хувьтай

Аймгийн төсөвт 20,6 сая төгрөг төвлөрүүлэхээс 11,2 сая төгрөг төвлөрүүлж 54 хувьтай, Орон нутгийн орлогод 11,2 сая төгрөг төвлөрүүлэхээс 21,0 сая төгрөг төвлөрүүлж 188 хувьтай тус тус төвлөрүүлсэн байна.

Улсын бүртгэлийн чиглэлээр:

04 сарын 21-ний байдлаар өссөн дүнгээр иргэний гэр бүлийн байдлын төрсний бүртгэлд 6 хүүхэд

Гэрлэлт цуцлалтын бүртгэлд 1 хос

Нас барсны бүртгэлд 2 иргэн

Иргэний шинэчилсэн бүртгэлд 6 иргэн

Иргэний үнэмлэх үрэгдүүлж захиалсан 5 иргэнд тус тус үйлчилгээ үзүүллээ.

ХАНБОГД СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гаргасан бодлого шийдвэр

Ирсэн бичиг-92, Хугацаа хэтэрсэн-0, Шийдвэрлэсэн-25, Өргөдөл, гомдол-8, Засаг даргын захирамж А-10, Б-0, Засаг даргын тоот-52, Засаг даргын Тамгын газрын даргын тушаал-А-0, Б-2, Засаг даргын Тамгын газрын даргын Шуурхай

хурал-0, ИТХ-ын тогтоол -0 тус гаргасан байна. СОК-ийн хуралдаан 2 удаа хуралдсан байна.

Хоёр. Хурал зөвөлгөөн, сургалт, семинар, уулзалт

Хөл хорио болон вирүсийн дэгдэлтээс сэргийлэх зорилгоор СОК-ын хуралдааныг 2 удаа хийж шаардлагатай үүрэг даалгаварыг холбогдох байгууллага бүрт даалгаж ажилласнаас Гашуун сухайт боомтоор нүүрс тээвэрлэлт хийх ажлаар ажлын хэсэг гарч Гал унтраах 66-р анги болон Хайрхан баг Гашуун сухайт авто зам, Гэрээт цагдаагийн алба зэрэг хамтран ариутгал тусгаарлах байр болон бүртгэл хийж хяналт тавин ажиллаж байна. Нүүрс тээврийн явцад COVID-19 тохиолдол илрээгүй. Масктай аяныг зохион байгуулж төрийн байгууллагын ажилтнууд хамтран иргэдэд маск тараах шаардлага тавих сурталчилах ажлыг зохион байгуулсны дүнд иргэдийн маск зүүх идвэх нэмэгдсэн байна.

2020 оны хугацаат цэрэг татлагын 1-р ээлжийн цэрэг татлагыг ажилттай зохион байгуулж ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж өгсөн үүрэг чиглэлийн дагуу зохион байгуулж байна. Аймгийн засаг даргын бүх сумдын дарга эрхлэгчтэй хийсэн цахим хуралд 42 хүний ирцтэйгээр оролцов.

СДЭ: Шинэ коронавирусын өвчний талаар тухайн цаг үеийн мэдээлэл, сурталчилгааг Ханбогд сум дундын эмнэлгийн page хуудсанд өдөр бүр тогтмол байршуулж байна.

Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газарт өдөр бүр томуугийн мэдээг 7-8 цагийн хооронд мэдээлэлж байна.

Сумын онцгой комиссад өдөр бүр 2 удаа амбулаторийн үзлэг, хэвтэн эмчлүүлэгчийн тоо, алс ойрын дуудлага зэрэг мэдээг тогтмол өгч байна.

ЭМГ-аас шинэ коронавирусын талаар цаг үеийн мэдээллээр 7 хоног бүрийн лхавга, баасан гаригуудад теле хурлаар зөвөлгөө, мэдээллээр ханган ажил лаж байна.

Сумын эмнэлэгт зөөврийн рентген аппаратыг Эрүүл мэндийн яамнаас хүлээлгэн өгсөн.

“Гоёот транс” ХХК-с зайнаас халуун хэмжигч халууны шил-1ш, амны хаалт /нэг удаагийн/-50ш, бээлий-50ш, гар ариутгагч гель-1ш өгсөн.

ЕPIROC ХХК-с 300 ширхэг хамгаалах хувцас /коврол/-ыг өгсөн.

ЭМЯ, Аймгийн ОК, Оюу толгой ХХК-с усны гутал, нүдний шил, нүүрний хаалт, цогцос хадгалах уут, зайнаас халуун хэмжигч, автомакс, ахуйн бээлий, амны хаалт /нэг удаагийн/, хамгаалах хувцас /комбинзон/, цэрний шинжилгээний сав, малгай /нэг удаагийн/, улавч, хормогч хулдаасан, гар ариутгагч, ариутгалын бодис зэрэг эмнэлгийн нэн шаардлагатай хамгаалах хэрэгсэлийг өгч халдвартын тасагт ажиллах 1,2,3-р баг, алсын дуудлагын 1,2-р баг, Хайрхан багын эмчид хувиарлан бэлэн байдлыг ханган ажиллаа.

Төрөх тасагт шинэ иргэний өрөөг шинээр тохижуулж Сумын дундын эмнэлгийн эрхлэгчийн өрөөнд хүндэтгэлийн буланг өөрсдийн нөөц боллоцоог ашиглаж хийлээ.

Мухар олгойн мэс заслыг м/з-н их эмч А.Зулбаяр, Д.Өлзийсайхан, Д.Батхүү, сувилагч А.Дэлгэрцэцэг, Т.Алимаа, үйлчлэгч Н.Чулуунцэцэг нар амжилттай хийсэн.

Сумын төвийн хогийн цэг дээр эмнэлгийн гаралтай хог хаягдлын цэгийг шинэчлэн хашаажуулан, хаягжуулсан. Эмнэлэг дотор эмнэлгийн гаралтай хог хаягдлыг түр хадгалах байрыг хийсэн.

Эмнэлгийн эмгэг хог хаягдлын ихэсийн нүхийг ЭМС-ын 505 тоот тушаалын дагуу шинэчилсэн.

Халдвараас сэргийлэн төрөх, халдвартын тасгуудын гадна болон дотор хаалгуудад гар ариутгалын суурь 8 ширхэгийг хийж байршуулсан.

Сумын улаан загалмайн хорооноос ор-20ш, түмбүүчик-2ширхэгийг өгч Хайрхан багийн тусгаарлах байранд байршуулсан.

Сумын цэрэг татлага IV/20-IV/21-ны хооронд болж байгаа ба Үлэмжийн чанар соёлын төвийн байранд эмнэлгийн үйлчлэгч Н.Чулуунцэцэг, Б.Нарантуяа, Ц.Амаржаргал нар ариутгал халдваргүйжүүлэлт хийж байна. Мөн эмнэлгийн 2 ажилтан комиссоор орж байгаа залуучуудын халуун, гар ариутгалыг хийж байна.

Тусгаарлалтад Д.Ууганбат 34 настай эрэгтэй. III/31-IV/20-ыг хүртэл 21 хоногийн хугацаанд тусгаарлаж байх хугацаанд биеийн байдал сайн илэрсэн шинж тэмдэггүй учир IV/20-ны өдөр гэрийн хяналтанд шилжүүлсэн.

Болор дэлгүүрийн хамт олноос эмнэлэгт хогийн сав 20 ширхэгийг өгсөн.

Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлж маскаа зүүх аянд нэгдсэн.

Сургууль: Багш нар теле хичээлийн хамрагдалтанд анхаарал хандуулж олон нийтийн газруудад багш нарыг ээлж гарган эргүүлд гарган ажиллаж байна.

Цэцэрлэг: Их булаг орчмын цэвэрлэгээг хамт олноороо санаачлан амжилттай зохион байгуулав.

Ковид-19 өвчний эсрэг Аймгийн Онцгой комисст байгууллагаараа 100.0 төгрөгийн хандив шилжүүлсэн.

Бүлгүүдийн нийт хүүхдүүдийн Теле хичээлд хамрагдалтанд хяналт тавьж ажиллаж байна. 4. Маскаа зүүцгээе аянд бүгд оролцож хуваарьт газартаа уриалга брошюр барьж жагсацгаав.

22-р цэцэрлэг: Хуваарийн дагуу өдөр бүр багш ажилчид 2, 2-оороо Гоёот, Хөөвөр, Галбын наран гэсэн газруудаар тогтмол эргүүл хийж, дэлгүүрүүдэд захирамж зөвлөмж өгч, гадуур явж байгаа хүүхдүүд болон хүмүүст хяналт тавьж ажиллаж, өвчлөлийн талаарх зөвлөгөө зөвлөмжийг тарааж эргүүлийг илтгэх хуудсыг цаг тухай бүрт нь илгээж ажиллаж байна. ЗАН, багш нар хамтран “Цахим хичээл” бэлтгэж нийт 15 хичээлийг хүүхдүүдэд онлайнаар хүргэсэн.

7 хоногт 2 удаа байгууллага дээрээ их цэвэрлэгээ ариутгал хийж байна.

29-р цэцэрлэг:

2019. 04 сарын 14 өдөр Өмнөговь аймгийн удирдлагуудаас зохион байгуулсан цаг үеийн байдалтай холбоотой онлайн хуралд Б.Болорцэрэн хамрагдсан.

Бусад ажлууд:

Хог цэвэрлэгээний ажлыг байгууллага бүр дотоодоо зохион байгуулж ариутгал хийсэн ба архи согтууруулах ундаагаар үйлчилж худалдан борлуулах ажлыг 7 хоног бүрийн мягмар, пүрэв гаригаас бусад үед худалдаалахыг хориглож хяналт тавин ажиллаж байна. Мөн өрх гэр бүлийг дэмжих жилийн хүрээний Нээлтийг 5 сарын 15-ний өдөр зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангуулан ажиллаж байна.

ХАНХОНГОР СУМ

Нэг.Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр:

Сумын засаг даргын 17 захирамж гарсан. Үүнээс Коронавирусын халдварын үед ажиллах зураглал, бүрэлдэхүүн батлах тухай -1, газар эзэмшүүлэх тухай-1, газар өмчлүүлэх тухай-1, захирамж хүчингүй болгох тухай-1, цэрэг татлагын ажлыг зохион байгуулах тухай-1, мал эмнэлгийн үйлчилгээний зардалд санхүүжилт олгох тухай-4, ажлын хэсэг байгуулах-3, арга хэмжээ хэрэгжүүлэх тухай-1, гамшгаас хамгаалах арга хэмжээнд хөрөнгө зарцуулах тухай-1, гэрээ байгуулж санхүүжилт олгох тухай-2, 2020 оны төсвийн эдийн засгийн ангилал, сар улирлын хуваарь өөрчлөлт оруулж батлах тухай-1, Засаг даргын тамгын газрын даргын тушаал 8 гарсан.

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт:

Сумын онцгой комисс 2 удаа хуралдсан. Сумын шуурхай штабын ажиллах чиг үүрэг, нийтийн эзэмшлийн талбайн ариутгал цэвэрлэгээ, байгууллага айл өрхүүдийн 00 цэг ариутгал хийх, цэрэг татлагын үед хэрхэн ажиллах талаар хэлэлцсэн. Амьжиргаа дэмжих зөвлөл 2 удаа хуралдаж орон нутгийн болон хөдөлмөр нийгмийн халамжийн чиглэлээр зарласан төслүүдийг хүлээн авч эрэмбэлэн ажиллалаа. НҮБ-аас зохион байгуулсан сургалт, “Цахим тест боловсруулах арга зүй” сургалтанд 20 багш хамрагдсан

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээ:

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 1 удаа хуралдсан. Хурлаар Төрийн шагналын материал хэлэлцэн уламжлах тухай, Амьжиргаа дэмжих зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай, Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай, Сонгуулийн сурталчилгааны байршлуудыг тогтоох тухай, Сумын ИТХурлын Төлөөлөгчдийн тоог тогтоож, тойрогт ногдох мандатын тоог хувиарлах тухай, Амьжиргаа дэмжих зөвлөлийн 2019 онд хийсэн ажлын тайланг хэлэлцэж үүрэг чиглэл өгөх тухай, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2019 онд хийсэн ажлын тайланг хэлэлцэж үүрэг чиглэл өгөх тухай, Сумын 2020 оны 1 дүгээр улирлын төсөв санхүүгийн орлого, зарлагын талаархи мэдээлэл авах тухай, ИТХ-ын Тэргүүлэгчдийн 1 дүгээр улирлын ажлыг дүгнэх тухай, БИНХ-ын дарга нарын 1 дүгээр улирлын ажлыг дүгнэх тухай, Эрүүл мэндийн төвийн 4 айлын орон сууцыг хувьчлах талаар, Хөрөнгө данснаас хасах санал уламжлах тухай тус тус хэлэлцэж шийдвэрлэсэн.

Шинэ коронавирусын халдвараас хамгаалах ажлын хүрээнд сумын онцгой комиссоос 2 удаа хуралдаж үүрэг чиглэл өгч ажиллалаа. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн Монгол Улсын Засгийн газрын болон улсын онцгой комиссын тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Сумын шуурхай штабыг ажиллуулж байна. 2020 оны цэрэг татлагын ажлыг зохион байгуулсан. “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аян -2020” арга хэмжээг төлөвлөгөө гарган батлуулж ажиллаж байна. Сумын засаг даргаас “Өрх гэр

бүлийн хөгжлийг дэмжих” жилийн хүрээнд заавал хөгжих 30 өрхийг сумын хэмжээн дэх төрийн болон төрийн өмчит байгууллага , ААН-үүдэд хуваарилан өгч хамтран ажиллах чиглэл өглөө. Сумын эрүүл мэндийн төв коронавирусын халдвараас сэргийлэх тушаал шийдвэрүүд болон хамгаалах хувцас хэрэгсэл өмсөх, тайлах дарааллын талаар нийт 4 удаа эмч мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулсан. Мөн эрүүл мэндийн цахим хуудсанд 50 гаруй нэр төрлийн зөвлөмж , зөвлөгөө байршуулсан. Аймгийн Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан шинэ коронавирусын үед авах арга хэмжээ, бэлэн байдлыг ханган ажиллах талаар аудио хуралд 2 удаа эмч ажилчид хамрагдлаа. Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн хүрээнд хамгаалалтын төлөвлөгөө боловсруулж дуусав.

Мэргэжлийн сургалттай сургуулиас теле хичээлийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаж байна. Цахим тандах шалгалтыг зохион байгуулж үр дүнг танилцууллаа. ЭЕШ-ын бэлтгэл ажлын хүрээнд 12-р ангийн сурагчдын дунд “7 хоногийн Онцлох хүүхэд”-г шалгаруулж байна. Үүнд 12-р ангийн 12 сурагч хамрагдаж байна. Хөл хориотой үед сурагчдынхаа дунд онлайнаар доорх уралдаануудыг зохион байгуулж байна. 1-12р ангийн сурагчдын дунд “Сайхан бичиг” уралдаанд зохион байгуулсан. Үүнд 24 хүүхэд 28н бүтээлээр, “Дуурайн бичье” уралдаанд 3 хүүхэд, “Сэтгэх чадвараа хөгжүүлцгээе” уралдаанд 8 хүүхэд оролцсон. 1-7-р ангийн сурагчдын дунд “Хөгжилтэй явдал” гар зургийн уралдаанд 11 хүүхэд 11 бүтээлээр оролцлоо. Нийт 5 төрлийн уралдаан тэмцээнд 60 хүүхэд хамрагдсан байна.

Сургуулийн складын барилга, багуудад гаргах гүн өрмийн 5 худгийн гүйцэтгэлийг хүлээж авав.ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх “Тэсгэнийн худгуудыг цахилгааны эх үүсвэрт холбох”, “Эрүүл мэндийн төвд биохими, оношлогооны төхөөрөмж нийлүүлэх” зэрэг ажлуудын худалдан авах ажиллагаа явагдаж байна. Аймгийн төсвөөс эрх шилжин гүйцэтгэх “Услалтын системийн засвар, Нарийны услалтын систем”-ийн засварын төсөв хийх захиалга өгсөн. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр сургуулийн болон дотуур байрны засварын ажил эхэлсэн бөгөөд гүйцэтгэл 30 хувьтай байна. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Ханхонгор сумын түүхэн номын эмхтгэл хийх ажлын гэрээг байгуулсан. Сумын Эрүүл мэндийн байгууллагад био химийн аппарат нийлүүлэх ажлын тендер зарлагдсан.

Шинэ коронавирусээс хамгаалах тухай мэдээ мэдээллийг иргэдэд цахимаар байнга хүргэж анхааруулж ажиллаж байна. Мөн сумын онцгой комисст байгууллага, иргэдээс хандив ирсээр байна. Маскны нөөц: даавуун маск 1125, нэг хэрэглээний макс 1025 ш, N95 маск 400 ш байна. Мод тарих өдрийг угтан аймгийн БОАЖГ-т 5 төрлийн модны суулгацны захиалга авч хүргүүлсэн. Эрүүл мэндийн төвийн автомашины засварт иргэдийн хандивын хөдөлгөөн өрнөж, 1611,0 мянган төгрөг хуримтлууллаа. Сумын Онцгой комиссыг шаардлагатай тоног хэрэгслээр хангах иргэдийн үүсгэл санаачлага гарч 590,0 мянган төгрөгний хандиваар 15-20 км-т холбоо барих чадал бүхий 5 гар станц нийлүүлсэн. Онцгой комиссын үйл ажиллагааг дэмжиж иргэдээс 490,0 мянган төгрөгний хандив хуримтлагдсан.

Багт хийгдсэн : Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны саналыг авах ажлыг багуудад хүргүүлэн ажиллаж байна.

ХҮРМЭН СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн.

Ажлаас чөлөөлөх, ажилд томилох тухай, Архи согтууруулах ундаагаар үйлчлэхийг хориглох тухай, комисс томилох тухай гэсэн нийт 7 захирамж, ажлаас чөлөөх тухай, ажилд томилох тухай нийт 2 тушаал гарсан.

Орон нутгийн удирдлагаас гарсан шийдвэрийн дагуу сумын хэмжээнд халварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, халдваргүйтгэл, ариутгалын арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна.

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт

Сумын Онцгой комисс хуралдаж 3 удаа хуралдаж тусгай төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцэн, шаардлагатай тохиолдолд ажиллах хүн хүч, техник хэрэгсэл, шатахуун тослох материалын нөөц, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцсэн.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил, арга хэмжээ

ИТХурал: ИТХТэргүүлэгчдийн хуралдааныг 1 удаа тэргүүлэгчдийн 60%-ийн ирцтэйгээр хуралдуулж дараах асуудлуудыг хэлэлцэн тогтоолоор баталлаа.

ЕБСургууль: Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдлийг гаргахгүй байх чиглэлээр гарсан шийдвэрийг цаг алдалгүй шуурхай хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, байгууллагын цахим хаягаар багш, ажилчдад, багш нар эцэг, эх, асран хамгаалагч нарт зөвлөмж зөвлөгөөг хүргэж ажиллаж байна.

Шинэ коронавирусын халдварын болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдал, хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлж, хариуцлагатай жижүүр томилон ажиллуулж байна

Эрүүл мэндийн төв: Сүрьеэгийн эсрэг өдрөөр сүрьеэгийн талаар 10 төрлийн зөвлөмжийг байгууллагын цахим хуудсан байршуулсан. Мэдээлэлд 26 хүн хандсан байна. Хоёр грүпт шторкыг байрлуулсан. 41 хүн хандсан. Амбулаториор үйлчлүүлсэн 41 иргэнд сүрьеэгийн сурталчилгааны материал тарааж, сурталчилгаа хийсэн. Байгууллагын цахим хуудсан 30 удаагийн мэдээлэл зөвлөмж оруулж, 60 хүн хандсан.

36 айл өрхүүдэд ариутгал хийх заавар өгч, жорлон муу усны цооногны ариутгалыг айл өрхүүдээр хийлгэсэн.

Халдвар хамгаалалтын хувцас хэрэглэлийг өмсөх тайлах дараалал болон гар угаах, халдваргүйтгэлээр 2 удаа үзүүлэх сургалтыг 15 эмч ажилчдад зохион байгуулсан.

20 хүүхдэд товлолын дархлаажуулалтанд хамруулсан байна.

Цэцэрлэг: Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдлийг гаргахгүй байх чиглэлээр гарсан шийдвэрийг цаг алдалгүй шуурхай хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, байгууллагын цахим хаягаар багш, ажилчдад, багш нар эцэг, эх, асран хамгаалагч нарт зөвлөмж зөвлөгөөг хүргэж ажиллаж байна.

Соёлын төв: Улс болон аймгийн хэмжээнд урлаг соёл, спорт, хурал зөвлөгөөн, олон нийтийг хамарсан арга хэмжээг хориглосонтой холбогдуулан Соёл спортын төвөөс төлөвлөсөн ажлууд тодорхой хугацаагүйгээр хойшлогдож, зарим ажлууд цуцлагдсан.

Байгаль орчин: Ирэх 7 хоногт Хүрмэн суманд нийт 427 ширхэг модыг 4 байгууллага, 14 иргэн захиалсан байна. Үүнээс ш хайлаас 128ш, Шар хуайс – 57ш, сухай – 83, жигд-92ш, улиас-67 ш тус тус төрлийн мод захиалсан.

Хөдөө аж ахуй: Сумын хэмжээнд нийт төлөвлөл зохих 65634 үүнээс ингэ 2157, гүү 2208, үнээ 566, эм хонь 14938 эм ямаа 45765 үүнээс 4 сарын 20-ны байдлаар 38,7 хувь /ингэ 1451, гүү 34, үнээ 40, эм хонь 7558, эм ямаа 16290/ төлөлсөн, төл бойжилт 100 хувь байна. Том малын 15 үүнээс тэмээ1, хонь 11, ямаа 39 хорогдолтой.

Отор нүүдлийн мэдээгээр 1 өрхийн 1200 толгой мал Дорноговь аймгийн Богд суманд аймагт отроор явж байна. Аймаг дотроо 10 өрхийн 5,0 мян толгой мал бусад сумдад оторлож явна. Тусгай хамгаалалттай газар нутагт 5 өрхийн 3,2 мян толгой мал хаваржиж байна.

Дөрөв. Тухайн сард зохион байгуулсан ажил

Аймаг, сумын Засаг даргын албан даалгаварыг хэрэгжүүлэн коронавирусээс урьдчилан сэргийлэх, зөвлөгөө мэдээлэл өгөх Шуурхай штаб албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд эргүүл, хяналтын үйл ажиллагааг хийж байна.

ЦОГТ-ОВОО СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр, гарсан үр дүн

Энэ сард сумын ИТХ-ын Тэргүүлэгчид 3 удаа хуралдаж, сумын Засаг даргаас А захирамж 4, ЗДТГазрын даргын А тушаал 4, Б тушаал 2 тус тус гарсан байна.

Хоёр. Хурал зөвлөгөөн, сургалт, семинар, уулзалт зохион байгуулсан байдал

Аймгийн удирдлагууд нийт сумдтай цахим хурал хийж мэдээ мэдээлэл өгч удирдлага арга зүйгээр хангаж ажилласан болно. Цахим хуралд ЗДТГазрын албан хаагчид болон байгууллагын дарга эрхлэгч нарыг хамруулсан нийт 27 албан хаагч хамрагдсан байна.

Угийн бичгийн дотоодын сургалтыг Улсын бүртгэгч Л.Мөнхцэцэг ЗДТГазрын мэргэжилтнүүдэд зохион байгууллаа.

Гурав. Орон нутгийн бодлого төлөвлөлтийн дагуу зохион байгуулсан ажил арга хэмжээ

Сумын ИТХ-ийн ажлын албанаас Төсөвт байгууллага болон ОНӨААТҮГ-ын “Шилэн дансны мэдээлэл”-д хөндлөнгийн хяналт хийж гарсан зөрчил дутагдлын талаар албан байгууллагуудад албан тоотоор зөвлөмж хүргүүлсэн.

“Өрх гэр бүлийн хөгжлийн жил”-ийн хүрээнд төлөвлөгөөний дагуу “Хашаандаа сайхан амьдарцгаая” аян, “Эрүүл иргэнээс эрүүл гэр бүл” аян, “Ураг удмын бичиг хөтөлж хэвшицгээе” уралдаан, “Онлайн дасгалын аян”, “Ахмадад ээлтэй байгууллага шалгаруулах уралдаан” зэрэг 6 ажлын Удирдамж боловсруулж цахимаар сурталчилан байгууллага, өрх гэр бүл, иргэдийг хамруулан зохион байгуулан ажиллаж байна.

2020 оны 04 сарын 15-ны өдөр Оюу толгой ХХК-ын “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-ийн 81,089,700 /наян нэгэн сая наян есөн мянга долоон зуун/

төгрөгний санхүүжилтын гэрээ хийгдэж, төслийн сонгон шалгаруулалтыг 2020 оны 04 сарын 17-ноос 05 сарын 01-ныг хүртэлх хугацаанд нийтэд зарлан ажиллаж байна.

320 хүүхдийн сургуулийн барилга, орлогод нийцсэн 10 айлын орон сууцны барилгын гүйцэтгэлийн ажлууд хийгдэж эхэлсэн.

Сумын хэмжээнд 7 тендэр зарлах ажлууд хийгдсэн. “Ногоон байгууламж”-ийн ажлын тендер шалгарч гэрээ байгуулахад бэлэн болсон.

Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг ажлын хэсэг гарч боловсруулсан.

2021 онд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаар иргэдээс санал асуулга авч ажиллаж байна.

Сумын Шуурхай штаб 12 цагаар ажиллаж аймгийн Шуурхай штабад 12, 19 цагуудад сум орон нутгийн талаарх мэдээ мэдээллээр хүргэн ажиллаж байна.

ЕБСургууль, 12-р цэцэрлэгийн багш, ажилчид хариуцлагатай эргүүл жижүүрийн үүрэг гүйцэтгэн ажиллаж байна\

Дөрөв. Тухайн сард зохион байгуулсан шинэлэг ажил, арга хэмжээ

Албан байгууллагуудын дунд Онлайн дасгалын уралдаан зарлагдаж албан байгууллагууд 11 цагийн ажлын байрны дасгал хөдөлгөөн хийж хэвшиж байна. Мөн байгууллагууд өөрсдийн хийж байгаа дасгалаа бүжиг хэлбэрт оруулж онлайнаар сурталчилан ажиллаж байна.

Тав. Багт зохион байгуулагдсан ажлууд

ЗДТГазраас 3-н багийн төвд очиж багийн үндсэн хөрөнгийн ашиглалт хамгаалалт, бүртгэлжүүлсэн байдалд хяналт шалгалт хийж ажилласан.

ЦОГТЦЭЦИЙ СУМ

Нэг. Орон нутгийн удирдлагаас гарсан бодлого шийдвэр:

ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурал 1 удаа хуралдав.

Сонгуулийн зурагт болон ухуулах хуудас байрлуулах байршил тогтоох тухай

Мандатын тоо тогтоох тухай, Сумын сонгуулийн хороонд ажиллах төрийн албан хаагчдын нэрсийг аймгийн Сонгуулийн хороонд хүргүүлэх тухай, Мал эмнэлгийн 2021 оны урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай, Ажлын хэсэг байгуулах тухай

Засаг даргын захирамж А/18 Б/1, Засаг даргын Тамгын газрын Тушаал А/7, Б/0 гарсан байна.

Хоёр. Хурал зөвлөлгөөн, сургалт, семинар, уулзалт

Өмнөговь аймгийн ЗДТГазраас нийт сумдыг оролцуулсан онлайн хурал зохион байгууллаа. Хуралд аймгийн Засаг дарга, агентлаг, хэлтсийн удирдлагууд оролцож цаг үеийн мэдээлэл, үүрэг чиглэл өгч ажиллалаа. Хуралд сумын төрийн байгууллагуудын дарга эрхлэгч нар, ЗДТГазрын нийт албан хаагчид оролцлоо.

Хөдөлмөр халамжийн дэргэдэх Амьжиргаа дэмжих зөвлөлийн хурал 2 удаа болж хүлээн авсан төслүүдийг хэлэлцэж аймагт хүргүүллээ.

Улаанбаатар хотын Хүүхэд гэр бүлийг хүчирхийлэлээс хамгаалах Үжин төвийн сургалтын менежерийн зохион байгуулсан сургалтанд Төсвийн байгууллагын дарга эрхлэгч, нийгмийн ажилтнууд хамрагдлаа.

Гурав.Орон нутгийн бодлого төлөвлөлт, тухайн сард зохион байгуулсан ажил, арга хэмжээ

2018-2020 онд сумын ИТХ-д 17 эх, Алдарт эхийн одон, үнэмлэхийг нөхөн авахаар материал ирүүлснийг Монгол улсын Ерөнхийлөгчийн тамгын газарт хүргэн ажиллав. Энэ хугацаанд Алдарт эхийн одон нөхөн авах эхчүүдийн материалыг архивын лавлагаатай нэг бүрчлэн тулгаж, утсаар тухайн иргэнтэй холбогдож, одон болон үнэмлэхийг нөхөн авав.

Хөдөлмөр эрхлэлтийн мэргэжилтэнд шинээр 55 иргэн анкет бөглөж 4 иргэн ажилд зуучлагдан орсон Шинэ коронавирустай холбогдуулан бүх уул уурхайн компани онлайнар болон хөдөлмөр эрхлэлтээр дамжуулан анкет бүрдүүлэлт хийлээ “Өрх гэр бүлийг дэмжих жил”-ийн хүрээнд хөдөлмөрийн насны хөдөлмөр эрхлээгүй өрхийн гишүүнийг ажилтай болгох богино хугацааны сургалтанд хамруулах, өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор

Цогтцэций сумын ААНБ болон төсвийн байгууллагуудаас 25 ажилчид тутамдаа нэг ХБИ болон Одой хүн ажиллуулж байгаа эсэх судалгааг ХХҮГ-т хүргүүлсэн. Мөн суманд үйл ажиллагаа явуулж буй 7-н ААНБ болон Төсвийн байгууллагуудаас 1-р улирлын ХАБЭА-н тайлан мэдээг авч ажиллаа. “Малжуулах төсөл”-д хамрагдах хүсэлтэй Сийрст, Цагаан-овоо, Билгэх багуудын нийт 24 өрхийн судалгааг гаргаж ХХҮГ-т хүргүүлсэн.

Төл бойжилт 100%, төллөлт 33%-тай байна. Хүнсний нөөцийн мэдээг долоо хоног бүрийн Лхагва гаригт, Түүхий эд худалдан авалтын мэдээг Пүрэв гаригт ХААГ хүргэн ажиллаж байна. Дундговь аймгийн сумдаас отор нүүдэл хийж буй сумдын удирдлагуудад мал сүргийг хаврын вакцинжуулалтын арга хэмжээ зохион байгуулах арга хэмжээ авах тухай албан мэдэгдэл хүргэсэн.

Өмнөговь аймгийн Санхүүгийн хяналт аудитын албанаас Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа Төсөвт байгууллага, Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрууд, Тусгай зориулалтын сангуудын 2019 оны санхүү, аж байдлын тайланд хяналт, шалгалтыг 14 хоногийн хугацаанд Өмнөговь аймгийн ЗДТГ-ын албан байран дээр бүх бичиг, баримтыг татан авч гүйцэтгэлээ. Хяналт шалгалтанд сумын ЗДТГ, ОНХС, ТС, ТЗС, 27-р цэцэрлэг, 2-р сургууль, Соёлын төв, 7-р цэцэрлэг, 6-р цэцэрлэг, Алимтан тойром ОНӨААТҮГазар, Тэгшдүүрэн тохижилт ОНӨААТҮГазар тус тус хамрагдлаа.

Сумын төсвийн орлогын оны эхний үлдэгдэл 259,064,679.61 төгрөг төсвийн орлогын төлөвлөгөө 597,060,200.00 төгрөг орохоос 392,773,859.77 төгрөг орж төсвийн байгууллагуудад олгосон зарлага санхүүжилт 436,285,800.00 төгрөг төсвийн орлогын үлдэгдэл 215,552,739.38 төгрөг байна.

ОНХС-аас энэ онд 13 нэр төрлийн 849,500,000 төгрөгийн бараа, ажил үйлчилгээ зарлагдахаас 233,500,000 төгрөгийн 6 бараа, ажил үйлчилгээ зарлагдсан байна Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар энэ онд 4 нэр төрлийн 971,897,100 төгрөгийн бараа, ажил үйлчилгээ зарлагдахаас 91,897,100 төгрөгийн 2 бараа, ажил үйлчилгээ зарлагдсан байна

Өрх гэр бүлийг дэмжих жилийн ажлын төлөвлөгөө батлуулж аймгийн ГБХЗХ-ийн газарт хүргүүлэв. Аймгийн ГБХЗХ-ийн газартай хамтарч зорилтот 2 өрхөд хоол хүнсний дэмжлэг үзүүлсэн.

Биотехникийн арга хэмжээг уул уурхайн компаниудтай хамтран Цэций уул, Хангинахын хад, Тугийн цохионд 150 боодол өвсийг тавьсан.

Сумын Засаг даргын 2020 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн А/73 дугаар Бүх нийтийн хог цэвэрлэгээг зохион байгуулах захирамжийн дагуу 2020.04.02-2020.04.15-ны хооронд Сумын төв, хээрийн цэвэрлэгээг зохион байгуулж нийт 432.5 тонн хог хаягдал 24 аж ахуй нэгж байгууллагын 586 албан хаагч оролцож

ажилласан. Сумын төвд ариутгал халдваргүйжүүлэлтийг хийсэн. Сумын төвийн ногоон байгууламжийн цэнэг усалгааг хийсэн.

Аймгийн онцгой комисст 6-р цэцэрлэгийн хамт олон 200.000 төгрөг, 7-р цэцэрлэгийн хамт олон 300,000 төгрөгийн хандив цуглуулж хүргүүлэв.

Шинэ коронавирусын халдварын үеийн өндөржүүлсэн бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд сумын шуурхай штаб, гадуур эргүүл, байгууллагуудын хариуцлагатай жижиг цэцэрлэгийн хуваарийн дагуу ажиллаж байна. Мөн байгууллага бүр өөрийн цахим хуудсаар дамжуулан орон нутгийн зарын группээр корона вирус халдвараас сэргийлэх зөвлөмж, мэдээллийг өдөр бүр нийтэлж, ЭМЯ-ны зөвлөмжүүдийг хуваалцаж байна.

Дөрөв : Багт хийгдсэн ажлууд:

Цагаан-Овоо багийн 35 өрхөд цаг үеийн мэдээлэл, витаминжуулалтын ажлаар ИТХ-ын нарийн бичгийн дарга Б.Ганболд ажиллав. Мөн Өмнөговь аймгийн ИТХ-ын 2016-2020 оны ажлын тайлан Цэцийн хөгжил сонинг айл өрхүүдэд хүргэн ажилласан байна.

4-р сарын 17-18-нд ээлжит цэрэг татлага зохион байгуулагдаж нийт 280 гаран хүн хамрагдсан.

Витаминжуулалтын аяны хүрээнд 3 багийн 100 гаруй өрхөөр орж витаминжуулалт хийхээс гадна, цэцэрлэгийн өмнөх болон сургуулийн насны хүүхдүүдэд хичээл даалгавар өгч ажиллалаа.

ШУУРХАЙ МЭДЭЭГ НЭГТГЭСЭН МЭРГЭЖИЛТЭН Г.УУГАНТУЯА